



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

ДУЛААН ХАНГАМЖИЙН ТУХАЙ (төсөл)

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1 Энэ хуулийн зорилт нь эрчим хүчний нөөцийг ашиглан дулааны эрчим хүчийг үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, хангах үйл ажиллагаа эрхлэх, дулаан хангамжийн барилга байгууламж барих, дулааны эрчим хүчийг хэрэглэх, дулаан хангамжийн салбарыг энэ хуульд заасан зорилтын дагуу хөгжүүлэх, хөгжлийн бодлого, төлөвлөлт хийх, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх болон дулаан хангамжийн төрийн зохицуулалттай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Салбарын зорилт

2.1 Салбарын техник, эдийн засгийн чадавхыг бэхжүүлж, бие даасан байдлыг хангах, дулаан хангамжийн системүүдийг оновчтой төлөвлөж, хөгжүүлэх замаар хүн ам, үйлдвэрлэлийн байгууламжийн дулааны хэрэглээг найдвартай, аюулгүй хангах нь салбарын үндсэн зорилт байна.

2.2 Дулаан хангамж нь дараах үндсэн шаардлагыг хангасан байна.

2.2.1 дулаан хангамж найдвартай байх;

2.2.2 дулаан хангамж аюулгүй байх;

2.2.3 дулаан хангамж үр ашигтай байх;

2.2.4 дулаан хангамж байгаль орчны шаардлагад нийцсэн байх.

2.3 Салбарын үндсэн зорилтуудыг хангахад дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:

2.3.1 салбарт өндөр үр ашигтай, дулааны хосолсон болон дан үйлдвэрлэл бүхий төвлөрсөн дулаан хангамжийн системийг тэргүүлэх чиглэл болгон хөгжүүлэх;

2.3.2 тухайн орон нутгийн онцлогоос хамаарч бие даасан болон хэсэгчилсэн дулаан хангамжийн системийг төлөвлөж, ашиглах, хөгжүүлэх;

2.3.3 дулаан хангамжийн системийг аюулгүй, найдвартай, үр ашигтай ажиллуулахын тулд дулаан хангамжийн салбарын оролцогч талуудын үүрэг, хариуцлагыг тодорхойлох;

2.3.4 дулааны техник, технологи, инженерчлэлийн оновчтой шийдэл, үр ашигт үндэслэсэн бодлого, төлөвлөлт болон хөтөлбөрт тулгуурлан дулаан хангамжийн найдвартай, аюулгүй байдлыг хангах, салбарын бие даасан байдал, тогтвортой хөгжлийг дэмжих;

2.3.5 дулаан хангамжийн үр ашигтай системийг дулаан хангамжийн хөгжлийн төлөвлөгөө (схем)-д үндэслэн бүсийн хүрээнд оновчтой төлөвлөж хөгжүүлэх;

2.3.6 дулаан хангамжийн системийн найдвартай, тогтвортой ажиллагааг хангахад шаардлагатай хөрөнгө оруулалтыг оновчтой бодлого, бодлогын хэрэгсэл болон механизмаар дэмжих, хөрөнгө оруулалтыг татах;

2.3.7 төр хувийн хэвшлийн түншлэлийн механизмыг ашиглан салбарт хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх;

2.3.8 салбарт татаас олгох нөхцөл, зарчим, шаардлага, зохицуулалтыг тодорхойлох;

2.3.9 байгаль орчны шаардлага, ногоон хөгжлийн бодлогод нийцсэн сэргээгдэх, бусад хүлэмжийн хийн ялгарал багатай эх үүсгүүр болон үр ашгийг дээшлүүлэх дэвшилтэт технологи нэвтрүүлэхийг дэмжих;

3 дугаар зүйл. Хуулийн нэр томьёоны тодорхойлолт

3.1. Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1. "бие даасан дулаан хангамжийн систем" гэж төвлөрсөн дулааны сүлжээнд холбоход төвөгшилтэй бус, байршилд дулааныг зарж борлуулах зорилготойгээр, зөвхөн өөрийн хэрэглээг хангах зориулалтаар барьж байгуулсан хэрэглэгчийн өмчлөл, эзэмшлийн дулаан хангамжийн системийг;

3.1.2. "дулаан" гэж дулаан зөөгчийн термодинамикийн үзүүлэлтийг өөрчлөх замаар хэрэглэгчийн хэрэгцээнд бий болгосон эрчим хүчийг;

3.1.3. "дулаан зөөгч" гэж дулааныг зөөвөрлөхөд ашигладаг шингэн эсхүл хийн бодис (ус, уур, агаар болон бусад бодис)-ыг;

3.1.4. "дулааны чадал" гэж дулааны эх үүсгүүр, дамжуулах, түгээх сүлжээ, хэрэглэгчийн түвшинд тодорхойлогдсон нэгж хугацаанд үйлдвэрлэсэн, дамжуулсан, хэрэглэсэн дулааны тоо хэмжээг;

3.1.5. "дулаан хангамжийн чанар" гэж энэ хуульд заасан дүрэм, норм, стандартын хүрээнд дулаан хангамжийн системийн термодинамикийн үзүүлэлтуудийн нийцлийг;

3.1.6. "дулаан хангамжийн найдвартай байдал" гэж хэрэглэгчдэд чанартай, аюулгүй дулаан хангамжийг тасралтгүй хүргэх дулаан хангамжийн системийн төлөв байдлын үзүүлэлтийг;

3.1.7. "дулаан хангамжийн хөгжлийн төлөвлөгөө (схем)" гэж тухайн орон нутаг, бүсийн онцлогийг харгалзан дулааны эрчим хүчиний ирээдүйн хэрэгцээг хангах зорилгоор боловсруулж баталсан, дулаан хангамжийн системүүдийг хөгжүүлэх схем, техник эдийн засгийн нарийвчилсан төлөвлөлтийг тодорхойлсон баримт бичгийг;

3.1.8. "дулаан хангамжийн бус" гэж байгаль орчны шаардлагыг хангасан, хэрэглэгчийн хэрэгцээнд нийцсэн, үндэслэл бүхий үнэтэй дулаанаар хэрэглэгчийг аюулгүй, найдвартай, үр ашигтай хангах нарийвчилсан төлөвлөгөөний үндсэн дээр тодорхойлсон бүсийг;

3.1.9. "дулаан хангамжийн систем" гэж барилга, орон сууц, үйлдвэрлэлийн байгууламжид зориулж үйлдвэрлэсэн дулааныг дулааны үүсгүүрээс шугам, сүлжээгээр дамжуулан хэрэглэгчийн тоноглол хүртэл хуваарилах систем, түүний иж бүрдлийг;

- 3.1.10. “дулаан үйлдвэрлэх” гэж дулааны анхдагч эх үүсвэрийг ашиглан стандартын шаардлага хангасан дулааны эрчим хүчийг хэрэглэгчийн хэрэгцээнд зориулж үйлдвэрлэх үйл явцыг;
- 3.1.11. “дулааны эх үүсгүүр” гэж дулаан үйлдвэрлэх зориулалттай дулааныг дангаар болон цахилгаантай хослон үйлдвэрлэх станц, халаалтын зуух, бусад суурилуулсан тоног төхөөрөмжүүдийн нэгдлийг;
- 3.1.12. “дулаан дамжуулах” гэж дулааны эх үүсгүүрээс үйлдвэрлэсэн дулааныг дулаан түгээх сүлжээ болон дамжуулах сүлжээнд шууд холбогдсон хэрэглэгчид тээвэрлэн хүргэх үйл явцыг;
- 3.1.13. “дулаан дамжуулах сүлжээ” гэж эх үүсгүүрээс дулаан дамжуулах төв хүртэлх 200 мм түүнээс дээш голчтой дулааны шугам, тоног төхөөрөмжийг;
- 3.1.14. “дулаан түгээх” гэж дулаан эсхүл дулаан зөөгчийг дулаан дамжуулах сүлжээнээс хэрэглэгчид хүргэх үйл явцыг;
- 3.1.15. “дулаан түгээх сүлжээ” гэж дулаан дамжуулах сүлжээнд холбогдсон 200 мм хүртэл голчтой шугам, тоног төхөөрөмж болон дулаан дамжуулах төв, түүнээс хэрэглэгчийн тоног төхөөрөмж хүртэлх шугам, тоног төхөөрөмжийг;
- 3.1.16. “дулаанаар хангах” гэж дулаан үйлдвэрлэгчээс шаардлагатай хэмжээний дулааныг худалдан авч, хэрэглэгчид худалдан борлуулах үйл ажиллагааг;
- 3.1.17. “дулаан хангамжийн байгууллага” гэж дулаан үйлдвэрлэх, дамжуулах болон түгээх, хангах үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагыг;
- 3.1.18. “дулаан үйлдвэрлэх байгууллага” гэж дулааны эх үүсгүүрээр хэрэглэгчийн хэрэгцээнд дулаан үйлдвэрлэх үйл ажиллагаа эрхэлж буй этгээдийг;
- 3.1.19. “дулаан дамжуулах байгууллага” гэж дулаан дамжуулах үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээдийг;
- 3.1.20. “дулаан түгээх байгууллага” гэж дулаан түгээх болон борлуулах үйл ажиллагаа явуулах этгээдийг;
- 3.1.21. “дулаан хэрэглэгч (цаашид “хэрэглэгч” гэх)” гэж дулааныг өөрийн хэрэгцээнд эсхүл дэд хэрэглэгчдэд худалдах зорилгоор худалдан авдаг этгээдийг;
- 3.1.22. “дулааны барилга байгууламж” гэж дулааны эх үүсгүүр, дулаан дамжуулах, түгээх сүлжээ болон технологийн зориулалттай бусад байгууламжийг;
- 3.1.23. “дулаан хангамжийн салбарын оролцогч талууд” гэж дулаан хангамжийн байгууллагууд болон дулааны эрчим хүч хэрэглэгчдийг;
- 3.1.24. “дэд хэрэглэгч” гэж хэрэглэгчийн дулааны сүлжээнд давхар холбогдсон эсхүл 2-р хэлхээнээс 3-р хэлхээ үүсгэн холбогдсон хэрэглэгчийг;
- 3.1.25. “мэдээллийн нэгдсэн систем” гэж дулаан салбарын хэвийн үйл ажиллагааг хангахад салбарын байгууллага хоорондын нэгдмэл уялдаа холбоог хангах, үйл ажиллагаанд хяналт, дүн шинжилгээ хийх, бодлого төлөвлөлтөд шаардлагатай мэдээллүүдийг нэгтгэн боловсруулах эрх бүхий байгууллагын мэдээллийн системийг;

3.1.26. “төвлөрсөн дулаан хангамжийн систем” гэж дулаан, цахилгааныг хослон үйлдвэрлэдэг болон дулааныг дангаар үйлдвэрлэдэг нэг болон түүнээс дээш эх үүсгүүрээс дулаан дамжуулах нэгдсэн сүлжээгээр диспетчерийн зохицуулалттайгаар эсхүл төв суурин газрын нийт хэрэглээний 50-иас дээш хувийг сүлжээгээр хангах үйл ажиллагааг;

3.1.27. “түлш” гэж дулаан үйлдвэрлэхэд ашиглаж болох боловсруулалтад орсон эсхүл байгаль дээр оршиж байгаа байгалийн баялагийн болон бусад эх үүсвэрийг;

3.1.28. “салбар” гэж дулаан хангамжийн салбарыг;

3.1.29. “халаалтын улирал” гэж барилга, байгууламжийг дулаанаар хангах шаардлагатай, хүний ажиллаж амьдрах таатай нөхцөлийг бурдүүлэх зорилгоор олон жилийн цаг агаарын дундаж үзүүлэлтэд тулгуурлан тогтоосон хугацааг;

3.1.30. “хэсэгчилсэн дулаан хангамжийн систем” гэж төвлөрсөн дулааны сүлжээнд холбох боломжгүй бүс, байршилд нэгдмэл ашиг сонирхолтой, эсхүл хоорондоо харилцан зөвшилцсэн этгээдүүд өөрсдийн хувийн орон байрны хэрэглээний дулаанаа хангадаг дулаан хангамжийн системийг;

3.1.31. “хэрэглэгчийн тоноглол” гэж хэрэглэгчийг дулааны сүлжээнд холбох, түүнийг дулаанаар хангахад шаардлагатай техник, тоног төхөөрөмжийн цогцыг;

ХОЁРДУГААР БҮЛЭГ. САЛБАРЫН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ БА ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

4 дүгээр зүйл. Салбарын бодлого, төлөвлөлт

4.1 Салбарын хөгжлийн бодлого, төлөвлөлт (цаашид “хөгжлийн бодлого, төлөвлөлт” гэх)-ийг улсын нэгдсэн хөгжлийн бодлого, төлөвлөлтөд нийцүүлэн энэхүү хууль болон Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийг удирдлага болгон хийнэ.

4.2 Хөгжлийн бодлого, төлөвлөлт нь Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5-д заасан зарчмын шаардлагыг хангасан байна.

4.3 Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн урт ба дунд хугацааны баримт бичгийг төрийн захиргааны төв байгууллага салбарын судалгаа, шинжилгээний мэргэшсэн байгууллага, салбарын мэргэжлийн холбоодын оролцоотойгоор боловсруулах ба урт хугацааны бодлого, төлөвлөлт эхлэхээс өмнөх жилийн сүүлийн хагас жилд багтаан; дунд хугацааны бодлого, төлөвлөлт эхлэхээс өмнөх жилийн сүүлийн улиралд багтаан батлах үүрэгтэй.

4.4 Төрийн захиргааны төв байгууллага улсын хөгжлийн урт ба дунд хугацааны бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулахад өөрийн эрхлэх асуудлын хүрээнд оролцохдоо энэ хуулийн 4.3-т заасны дагуу баталсан салбарын хөгжлийн урт ба дунд хугацааны бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг үндэслэнэ.

4.5 Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулах байгууллага, хувь хүн, түүнд шаардлагатай санхүүжилтийг шийдвэрлэх асуудлыг төрийн захиргааны төв байгууллага хариуцна.

4.6 Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт дараах асуудлуудын хүрээнд ахиц дэвшил гаргах нэгдсэн бодлогыг тодорхойлж, түүнд хүрэх нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулна:

- 4.6.1 дулаан хангамжийн системийн хэтийн төлөв;
- 4.6.2 аюулгүй, найдвартай хангамж;
- 4.6.3 техник, технологи;
- 4.6.4 санхүү, эдийн засаг, үр ашигтай байдал;
- 4.6.5 зах зээлийн загвар, тогтолцоо;
- 4.6.6 хүний нөөц;
- 4.6.7 хөрөнгө оруулалт;
- 4.6.8 бусад.

4.7 Урт хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг нь салбарын 30 жил хүртэл хугацааны хөгжлийн бодлогыг тодорхойлох бөгөөд төрийн захиргааны төв байгууллага хэрэгжилтийн явцыг таван жил тутамд, гүйцэтгэлийн тайланг дуусгавар болох хугацаанаас хоёр жилийн өмнө Засгийн газарт тус тус тайлагнана.

4.8 Дунд хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг нь салбарын 10 жил хүртэл хугацааны хөгжлийн бодлогыг тодорхойлох бөгөөд төрийн захиргааны төв байгууллага хэрэгжилтийн явцыг гурван жил тутамд, гүйцэтгэлийн тайланг дуусгавар болох хугацаанаас нэг жилийн өмнө тус тус Засгийн газарт тайлагнана.

4.9 Урт ба дунд хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нэмэлт өөрчлөлт оруулахдаа Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 19 дүгээр зүйлийг баримтална.

4.10 Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг нь дараах зүйлээс бүрдэнэ:

- 4.10.1 зорилго, зорилт;
- 4.10.2 суурь түвшин;
- 4.10.3 шалгуур үзүүлэлт: зорилтот түвшний, төлөвлөгөөт түвшний;
- 4.10.4 хүрэх үр дүн;
- 4.10.5 хөрөнгө оруулалт, санхүүжилт;
- 4.10.6 хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл арга хэмжээ.

4.11 Урт ба дунд хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийг хэрэгжүүлэх богино хугацааны хөтөлбөрийг төрийн захиргааны төв байгууллага өмнөх жилийн 04 дүгээр сарын 15-ны өдрийн дотор жил бүр боловсруулж батална.

4.12 Төрийн захиргааны төв байгууллага нь богино хугацааны хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулж, гүйцэтгэлийг дараа жилийн 3 дугаар сарын 31-ний өдрийн дотор Засгийн газарт тайлагнах үүрэгтэй.

4.13 Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээг төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлнэ.

5 дугаар зүйл. Дулаан хангамжийн хөгжлийн төлөвлөгөө (схем)

5.1 Нийслэл Улаанбаатар хот, улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хот болон аймагт салбарын үйл ажиллагаа, хөгжил нь урт болон дунд хугацааны дулаан хангамжийн хөгжлийн төлөвлөгөө (схем)-д үндэслэнэ.

5.2 Дулаан хангамжийн хөгжлийн төлөвлөгөө (схем) нь энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан дулаан хангамжийн бүсэд суурилж төлөвлөгднө.

5.3 Урт хугацааны хөгжлийн төлөвлөгөө (схем)-ийг 10 хүртэл жилээр салбарын хөгжлийн бодлого, төлөвлөлтэд үндэслэн, дунд хугацааны хөгжлийн төлөвлөгөө (схем)-ийг 5 хүртэл жилээр урт хугацааны хөгжлийн төлөвлөгөө (схемд)-д үндэслэн

хотын Захирагч, аймгийн Засаг дарга тус тус боловсруулж, Иргэдийн төлөөлөгчдийн хурлаараа батлуулна.

5.4 Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулах байгууллага, хувь хүн, түүнд шаардлагатай санхүүжилтийг шийдвэрлэх асуудлыг орон нутгийн засаг, захиргаа хариуцна.

5.5 Салбарын урт ба дунд хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлттэй уялдаатай байдлыг хангах зорилгоор урт ба дунд хугацааны хөгжлийн төлөвлөгөө (схем)-ийг боловсруулах эрх бүхий этгээд төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцэж, харилцан хүлээн зөвшөөрсөн байх шаардлагатай.

5.6 Дулаан хангамжийн хөгжлийн төлөвлөгөө (схем)-д дараах зүйлсийг заавал тусгана:

5.6.1 дулааны бодит үзүүлэлт-тухайн нутаг дэвсгэрт дулаан хангамжийн системийн өнөөгийн хүчин чадал, ачаалал, хэрэглэгчийн бүтэц, сүлжээний хэмжээ, дулааны алдагдал, ашигт үйлийн коэффициент, найдвартай ажиллагаа зэрэг хэмжигдэхүйц тоон болон чанарын үзүүлэлтүүд болон бусад мэдээллүүд;

5.6.2 дулааны зорилтот үзүүлэлт- тухайн нутаг дэвсгэрт дулаан хангамжийн системийн үр ашиг, найдвартай байдал, хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулах, хэрэглэгчдэд хүртээмжтэй байх зорилтыг хангах тоон болон чанарын хэмжигдэхүйц үзүүлэлт болон бусад мэдээллүүд;

5.6.3 хот, тосгоны болон засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн нөхцөл байдал, шинж чанарыг харгалзан олон төрлийн дулаан хангамжийн системийн оновчтой хослол бий болгох;

5.6.4 дулаан хангамжийн одоогийн болон ирээдүйн эрэлт хэрэгцээг хангах хувилбар;

5.6.5 хот, тосгоны болон засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн батлагдсан ерөнхий төлөвлөгөө, бүтээн байгуулалт хөгжлийн схемтэй уялдсан байдал;

5.6.6 бүх хэрэглэгчийг дулаанаар хангах эрх тэгш нөхцөл болон төлбөрийн ялгаваргүй шатлал;

5.6.7 дулаан хангамжийн чанар, найдвартай байдлыг хангах, байгаль орчинд үзүүлэх хор хөнөөлийг багасгах, эрчим хүч болон нөөцийг хэмнэх технологийг хөгжүүлэх, сэргээгдэх эрчим хүчний эх үүсгүүрийн ашиглалтыг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалт, санхүүжилтийг шийдэх болон бусад хүчин зүйлийг харгалзан үзсэн салбарыг хөгжүүлэх оновчтой хувилбар.

5.7 Хотын Захирагч, аймгийн Засаг дарга нь дулаан хангамжийн хөгжлийн төлөвлөгөө (схем)-г боловсруулахдаа дулааны зорилтот түвшинд хүрэх арга хэмжээ, хэрэгжүүлэх хугацаа, цар хүрээ, тэргүүлэх чиглэл болон санхүүжилтийн эх үүсгүүрийг орон нутгийн нөхцөл байдлыг харгалзан тодорхойлно.

6 дугаар зүйл. Дулаан хангамжийн бүс

6.1 Байгаль орчны шаардлагыг хангасан, хэрэглэгчийн хэрэгцээнд нийцсэн, үндэслэл бүхий үнэтэй дулаанаар хэрэглэгчийг аюулгүй, найдвартай, үр ашигтай хангах нарийвчилсан төлөвлөгөөний үндсэн дээр дулаан хангамжийн бүсийг тодорхойлно.

6.2 Хотын Захирагч, аймгийн Засаг дарга нь өөрийн харьяаллын нутаг дэвсгэр дэх дулаан хангамжийн бүсийг техник-эдийн засгийн үндэслэл болон бусад төлөвлөлттэй уялдуулан тодорхойлох, батлуулах эрхтэй байна.

6.3 Шинээр бүтээн байгуулалт хийх, хүн амын нягтаршил ихтэй нутаг дэвсгэрт дулаан хангамжийн бүсийг тодорхойлохдоо энэ хуулийн 6.1-д заасныг үндэслэн дулаанаар хангах хувилбаруудад дүн шинжилгээ хийж, хамгийн боломжит хувилбарт үндэслэнэ.

6.4 Хуульд өөрөөр заагаагүй бол дулаан хангамжийн байгууллага тухайн дулаан хангамжийн бүст хамаарах бүх этгээдийг дулааны сүлжээнд холбож, дулаанаар хангах үүрэгтэй.

6.5 Хот, тосгоны захирагч, Засаг дарга нь дулаан хангамжийн бүсийг тодорхойлсон шийдвэртээ дараах зүйлийг тусгана:

- 6.5.1 дулаан хангамжийн бүсийн хил хязгаар;
- 6.5.2 дулаан хангамжийн чанарт тавигдах ерөнхий шаардлага;
- 6.5.3 дулаан хангамжийн байгууллагын тухайн дулаан хангамжийн системийг хөгжүүлэх үүрэг;
- 6.5.4 хүчин төгөлдөр үйлчилж эхлэх огноо.

6.6 Дулаан хангамжийн бүсийг тогтоох үед дулааны сүлжээнд холбогдоогүй байсан бөгөөд бие даасан дулаан хангамжаар өөрийгөө хангаж байсан этгээдийг дулааны хангамжийн сүлжээнд заавал холбогдохыг шаардахгүй.

6.7 Дулаан хангамжийн бүс дэх хэрэглэгч нь дулааны сүлжээнээс авч байгаа дулаанаас гадна сэргээгдэх эрчим хүчний эх үүсгүүр, эсхүл бусад төрлийн хүлэмжийн хийн ялгарал багатай эх үүсгүүрээс үйлдвэрлэсэн дулааныг нэмж худалдан авч болно.

ГУРАВДУГААР БҮЛЭГ. ТӨР, ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА

7 дугаар зүйл. Улсын Их Хурлын бүрэн эрх

7.1 Улсын Их Хурал дулаан хангамжийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

- 7.1.1 салбарын талаарх төрийн бодлогын үндсэн чиглэлийг улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хүрээнд тодорхойлох;
- 7.1.2 салбарын хууль тогтоомжийн биелэлтийг хянан шалгах;
- 7.1.3 салбарын хууль тогтоомж, төрийн бодлогын хэрэгжилт, түүний үр дүнг хянан шалгаж, хэрэгжүүлэхийг Засгийн газраас шаардах, Үндсэн хууль, бусад хуульд заасан арга хэмжээ авах;
- 7.1.4 Улсын Их Хурал салбарын төрийн бодлогын үндсэн чиглэлийг тодорхойлохдоо өндөр үр ашигтай, техник эдийн засгийн оновчтой шийдэл бүхий төвлөрсөн дулаан хангамжийн системийг хөгжүүлэх бодлого баримтлах, эн нь техник, эдийн засгийн хувьд боломжгүй, эсхүл үр ашиггүй бол хэсэгчилсэн, бие даасан болон тархмал дулаан хангамжийн систем үүсгэх нөхцөлийг бүрдүүлэх замаар улс орны дулааны хэрэгцээг аюулгүй, найдвартай хангах, өндөр үр ашигтай, байгаль орчинд ээлтэй, сэргээгдэх эрчим хүчний техник технологийг нэвтрүүлэх, дэмжих бодлого баримталж, салбарын хөгжлийн тогтвортой байдлыг хангах үүрэгтэй.

8 дугаар зүйл. Засгийн газрын бүрэн эрх

8.1 Засгийн газар дулаан хангамжийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

8.1.1 салбарын хууль тогтоомжийн биелэлтийг улс орон даяар зохион байгуулж, хангах;

8.1.2 улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хүрээнд салбарын бодлого, үндсэн чиглэлийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн барих, батлуулах, гарсан шийдвэрийг биелүүлэх;

8.1.3 салбарын бодлого, үндсэн чиглэлийн хэрэгжилтийг Улсын Их Хуралд тайлагнах;

8.1.4 салбарын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэрэгжилтийг зохион байгуулах, төрийн захиргааны төв байгууллагын тайланг хүлээн авах замаар хэрэгжилтэд нь хяналт тавих;

8.1.5 салбарын бодлого, үндсэн чиглэлийг хэрэгжүүлэхэд дараах дэмжлэгийг үзүүлэх:

8.1.5.а. дулаан хангамжийн системийн аюулгүй, найдвартай ажиллагааг хангах нөөц хүчин чадал бий болгох, дамжуулах сүлжээ барих, өргөтгөхөд төсвөөс санхүүжилт олгох;

8.1.5.б. төр хувийн хэвшлийн түншлэлийн механизмаар дулааны шинэ эх үүсгүүр, дамжуулах, түгээх сүлжээ барьж байгуулахыг дэмжих;

8.1.5.в. сэргээгдэх эрчим хүч болон өндөр үр ашигтай дэвшилтэт техник, технологи ашиглан хэсэгчилсэн болон бие даасан дулаан хангамжийн систем бий болгох сонирхлыг татвар, татаас, ногоон зээлийн механизмаар дэмжих;

8.1.5.г. хэрэглэгчдэд ирэх өндөр үнийн дарамтыг бууруулах зорилгоор бодит өртгөөс доогуур тарифыг нөхөх татаасын бодлогыг аажмаар халах бодлого баримтлах;

8.1.5.д. Засгийн газрын баталгаа гаргах;

8.1.5.е. бусад шаардлагатай дэмжлэг.

8.1.6 салбарын хөгжлийн бодлого, төлөвлөлт болон норм, нормативын баримт бичиг боловсруулах, эрчим хүчний үндэсний баланс гаргах асуудлыг хариуцсан эрчим хүчний салбарын судалгаа, шинжилгээний мэргэшсэн байгууллага байгуулах, зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэх, түүний дүрмийг батлах;

8.1.7 онцгой байдлын үед дулаан хангамжийн аюулгүйн нөөц бүрдүүлэх, хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэх, нөөцийн жагсаалтыг батлах;

8.1.8 дулааны сүлжээний техникийн аюулгүй байдал, эвдрэлээс урьдчилсан сэргийлэх, сэргээн засварлах нөхцөлийг багтаасан шугам сүлжээг хамгаалах дүрмийг батлах;

8.1.9 энэхүү хууль болон бусад хуульд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх.

9 дүгээр зүйл. Төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх

9.1 Төрийн захиргааны төв байгууллага дулаан хангамжийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

9.1.1 дулаан хангамжийн хууль тогтоомж болон Засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлэх;

- 9.1.2 салбарын хөгжлийн бодлого, төлөвлөлт болон түүний үндсэн чиглэлийг боловсруулахад шаардлагатай тооцоо, судалгаа, дүн шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг зохион байгуулах, боловсруулж, батлуулах, хэрэгжүүлэх, Засгийн газрын өмнө хуулийн хугацаанд нь тайлагнах;
- 9.1.3 салбарын дунд ба урт хугацааны дулааны зорилтот үзүүлэлтийг боловсруулж Засгийн газарт оруулж батлуулах;
- 9.1.4 салбарын байгууллагуудын дулаан үйлдвэрлэлт, дамжуулалт, түгээлт, борлуулалтын хэмжээ, суурь болон зорилтот түвшний үзүүлэлтүүд, эрчим хүч хэмнэх, үр ашгийг дээшлүүлэх зорилтуудыг батлах;
- 9.1.5 төсөл, хөтөлбөрийн зохион байгуулалт, хэрэгжилтийг хангах;
- 9.1.6 дулааны шинэ эх үүсгүүрийн талаар судалгаа хийх, шинэ дэвшилтэт техник, технологи, инновац нэвтрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах;
- 9.1.7 дулааны шинэ эх үүсгүүрийн техник, эдийн засгийн үндэслэлийг баталгаажуулах, магадлал хийх ажлыг зохион байгуулах;
- 9.1.8 салбарт төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд заасны дагуу төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжих төслийг төлөвлөх, холбогдох байгууллагад төслийн санал гаргах, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээний хэрэгжилтэд хяналт тавих;
- 9.1.9 дулаан хангамжтай холбоотой норм, нормативын баримт бичиг батлах, стандарт боловсруулах, эрх бүхий байгууллагаар батлуулах;
- 9.1.10 дулаан хангамжийн системийг барих, өргөтгөх, шинэчлэх, засварлахад зориулж улсын төсөвт тусгагдсан хөрөнгө оруулалт, татаасыг олгох;
- 9.1.11 салбарын хөгжлийн асуудлаар олон улсын байгууллагатай хамтран ажиллах;
- 9.1.12 салбарын мэргэжлийн хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэх;
- 9.1.13 хуульд нийцүүлэн салбарт мөрдөгдөх дараах дүрэм, журмыг батлах:
- 9.1.13.а. төвлөрсөн дулаан хангамжийн дүрэм;
- 9.1.13.б. дулааны эрчим хүчийг хэмжих, тооцох дүрэм;
- 9.1.13.в. дулааны барилга байгууламж болон тоног төхөөрөмжийн угсралт, засвар, ашиглалтын үед мөрдөх аюулгүй ажиллагааны дүрэм;
- 9.1.13.г. дулааны барилга байгууламж барих, ашиглалтад оруулах журам;
- 9.1.13.д. дулааны барилга байгууламж болон тоног төхөөрөмжийн зураг төсөлд магадлал хийх журам;
- 9.1.13.е. онцгой нөхцөл, гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн шинжтэй нөхцөл байдал үссэн тохиолдолд түлш, дулаан хангамжийн талаар мөрдөх журам;
- 9.1.13.ё. дулаан хангамжийн байгууллагын мэдээллийг эрчим хүчний салбарын мэдээллийн нэгдсэн санд бүртгэх журам.
- 9.1.14 энэхүү хууль болон бусад хуульд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх.

10 дугаар зүйл. Эрчим хүчний зохицуулах хорооны бүрэн эрх

10.1 Эрчим хүчний зохицуулах хороо (цаашид “Зохицуулах хороо” гэх) нь дулаан хангамжийн байгууллагуудад үзүүлсэн зохицуулалтын үйлчилгээний хөлсөөр санхүүжих, ашгийн бус байгууллага байна.

10.2 Зохицуулах хороо нь дулаан хангамжийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

10.2.1 дулаан хангамжийн байгууллагуудад тусгай зөвшөөрлийг олгох, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох, түүний нөхцөл, шаардлагын хэрэгжилтийг хянах, түүнтэй холбоотой мэдээллийг гаргуулах;

10.2.2 дулаан хангамжийн байгууллагууд нь өөрчлөн зохион байгуулагдах, тусгай зөвшөөрөлд заасан үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардагдах барилга байгууламж, сүлжээ, тоног төхөөрөмж, бусад эд хөрөнгийг шинэчлэх, өөрчлөх, тэдгээрийг өмчлөх эрхээ шилжүүлэх, барьцаалах нь тусгай зөвшөөрөлд заасан үйл ажиллагаанд нөлөөлөхөөр бол тухайн өөрчлөлтийг зөвшөөрөх эсэхийг шийдвэрлэх;

10.2.3 дулаан хангамжийн байгууллагуудын үйлчилгээний тариф болон хэрэглэгчдэд борлуулах дулааны тарифыг бодит өртөгт үндэслэн, зохих ашгийн түвшинг хангаж тогтоох, индексжүүлэлтийг хэрэгжүүлэх;

10.2.4 энэ хуулийн 45.2-д заасан дулаан хангамжийн байгууллагын хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг хянаж, хөрөнгө оруулалтыг нөхөн төлөх асуудлыг тарифын зохицуулалтаар шийдвэрлэх;

10.2.5 дулаан хангамжийн байгууллагуудын хооронд, эсхүл дулаан хангамжийн байгууллага болон хэрэглэгчийн хооронд үүссэн маргааныг харьяаллын дагуу шийдвэрлэх;

10.2.6 эрчим хүчний хэмнэлтийн бодлого, зохицуулалтыг тодорхойлох, хэрэгжилтийг зохион байгуулах чиг үүргийг Эрчим хүчний хэмнэлтийн хуулиар олгогдсон эрх хэмжээний хүрээнд хэрэгжүүлэх;

10.2.7 энэхүү хуульд заасан шаардлага, үндэслэл, зарчимд нийцүүлэн дараах баримт, бичгүүдийг боловсруулах, батлах:

10.2.7.а. дулааны аж ахуйн харилцааны дүрэм;

10.2.7.б. дулаан хэрэглэгчийн холболтын журам;

10.2.7.в. зохицуулалттай үйлчилгээний хөлс тооцох аргачлал;

10.2.7.г. жил бүрийн зохицуулалттай үйлчилгээний хөлс;

10.2.7.д. үнэ, тарифыг индексжүүлэх журам;

10.2.7.е. дулааны тариф тогтоох аргачлал;

10.2.7.ё. эрчим хүч үйлдвэрлэхэд ашиглах түлшний үнийг тогтоох аргачлал;

10.2.7.ж. дулаан хангамжийн байгууллагууд хооронд, эсхүл дулаан хангамжийн байгууллага болон хэрэглэгчтэй байгуулах гэрээний загвар.

10.2.8 аймаг, нийслэлийн зохицуулах зөвлөлийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, орон тооны гишүүдийг аймаг, нийслэлийн Засаг даргатай

зөвшилцөн томилж, чөлөөлөх;

10.2.9 төвлөрсөн, хэсэгчилсэн болон бие даасан дулаан хангамжийн системүүдийн нэгдсэн бүртгэлийг гаргах, нийтлэх;

10.2.10 дулаан хангамжийн байгууллагуудын техник эдийн засгийн үзүүлэлтүүдийг тусгай зөвшөөрлийн төрөл бүрээр нэгтгэн мэдээллийн цахим санд бүртгэх, салбарын мэдээллийн нэгдсэн системтэй холбох;

10.2.11 энэхүү хууль болон бусад хуульд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх.

11 дүгээр зүйл. Хотын Захирагч, аймгийн Засаг даргын бүрэн эрх

11.1 Хотын Захирагч, аймгийн Засаг дарга дулаан хангамжийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

11.1.1 тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид зориулан урт болон дунд хугацааны дулаан хангамжийн хөгжлийн төлөвлөгөө (схем)-ийг боловсруулж, иргэдийн төлөөлөгчдийн хурлаар батлуулах;

11.1.2 тухайн засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн дулаан хангамжийн хөгжлийн төлөвлөгөө (схем)-г хэрэгжүүлэх, гүйцэтгэлийг дүгнэх, тайлагнах, хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх;

11.1.3 дулаан хангамжийн системийн ашиглалтын найдвартай байдал, технологи, эдийн засгийн хүртээмжтэй байдлыг эрх бүхий байгууллагаас тогтоосон журмын дагуу хянах, үнэлэх, холбогдох байгууллагад санал хүргэх;

11.1.4 дулаан хангамжийн системийн халаалтын улирлын бэлэн байдлыг хангах төлөвлөгөөний биелэлт, техникийн бэлэн байдлыг шалгах, тайлагнах;

11.1.5 дулааны эх үүсгүүр, сүлжээ, хэрэглэгчийн тоноглолын засвар үйлчилгээ, үйл ажиллагааны явцад зохицуулалт хийх, дэмжлэг үзүүлэх хэрэгжилтэд хяналт тавих;

11.1.6 орон нутагт эрчим хүчиний мэргэжлийн хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэх;

11.1.7 зорилтот бүлгийн иргэдэд дулааныг хэмнэх болон эрчим хүчиний үр ашгийг дээшлүүлэхтэй холбоотой зардлыг нөхөх, нийгмийн тусlamж үзүүлэх журмыг боловсруулах;

11.1.8 дулаан хангамжийн системийн төлөв байдлын талаарх мэдээллийг цуглуулах, шинэчлэх, салбарын мэдээллийн нэгдсэн системд оруулах, дамжуулах, нийтлэх;

11.1.9 орон нутгийн дулаан хангамжийн системийн технологийн зөрчлийг бүртгэх;

11.1.10 халаалтын улиралд тасралтгүй, найдвартай ажиллахад зориулж дулаан хангамжийн байгууллагын түлш худалдан авах зардалд татаас олгох эсэх асуудлыг Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлж, шийдвэрлүүлэх;

11.1.11 дулаан хангамжийн байгууллагад одоо байгаа шугам, тоноглолын хүчин чадлыг өргөтгэх, шинэчлэх, сайжруулах, засвар үйлчилгээ хийх зорилгоор төсөл хэрэгжүүлэн гадаад зээлийн төлбөрт батлагдсан журмын дагуу татаас олгох;

11.1.12 энэхүү хууль болон бусад хуульд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх.

12 дугаар зүйл. Аймаг, нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын бүрэн эрх

12.1 Аймаг, нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал дулаан хангамжийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

12.1.1 дулаан хангамжийн хөгжлийн төлөвлөгөө (схем)-ийг батлах;

12.1.2 дулаан хангамжийн хөгжлийн төлөвлөгөө (схем)-ний хэрэгжилтийн тайланг хэлэлцэх;

12.1.3 Дулаан хангамжийн байгууллагад орон нутгийн төсвөөс хөрөнгө оруулалт хийх, татаас олгох, эсэх асуудлыг хэлэлцэх;

12.1.4 зорилтот бүлгийн иргэдэд эрчим хүч хэмнэх болон эрчим хүчиний үр ашгийг дээшлүүлэх зардал, дулааны үйлчилгээний төлбөрийг нөхөн олгох, нийгмийн тусламж үзүүлэх журмыг батлах.

13 дугаар зүйл. Аймаг, нийслэлийн зохицуулах зөвлөлийн бүрэн эрх

13.1 Аймаг, нийслэлд дулаан хангамжийн зохицуулалтыг аймаг, нийслэлийн зохицуулах зөвлөл хэрэгжүүлнэ.

13.2 Аймаг, нийслэлийн зохицуулах зөвлөл нь дараах эрх, үүрэгтэй байна:

13.2.1 энэ хуульд заасны дагуу тусгай зөвшөөрөл олгох, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох;

13.2.2 олгосон тусгай зөвшөөрлийнхөө нөхцөл, шаардлагын хэрэгжилтийг хянах;

13.2.3 зохицуулах хорооны баталсан аргачлал, журмын дагуу харьяалах тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тариф, хэрэглэгчийн үнийг батлах, шалгах, нийтлэх.

13.2.4 төвлөрсөн, хэсэгчилсэн болон бие даасан дулаан хангамжийн системүүдийг бүртгэх;

13.3 Аймаг, нийслэлийн зохицуулах зөвлөл нь тусгай зөвшөөрөл олгохтой холбогдон гарсан зардлаа тусгай зөвшөөрлийн үйлчилгээний хөлснөөс санхүүжүүлнэ.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ДУЛААН ХАНГАМЖИЙН БАЙГУУЛЛАГА

14 дугаар зүйл. Дулаан хангамжийн байгууллага

14.1 Дулаан хангамжийн байгууллага нь дулааныг үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, борлуулах үйл ажиллагааны аль нэгийг, эсхүл эдгээр үйл ажиллагааг хамтад нь явуулдаг этгээд бөгөөд эрхэлж буй үйл ажиллагаанд хамаарах дулааны барилга байгууламж, тоног төхөөрөмж, сүлжээний өмчлөгч, эзэмшигч, ашиглагч нь байна.

14.2 Дулаан хангамжийн байгууллага өөрийн эрхлэх үйл ажиллагааны хүрээнд хамаарах дулааны барилга байгууламж, тоног төхөөрөмж, сүлжээг өмчлөөгүй тохиолдолд өмчлөгчтэй байгуулсан гэрээний үндсэн дээр эзэмшиж, ашиглаж болно. Энэ тохиолдолд эзэмшил, ашиглалтын нөхцөлийг гэрээнд нарийвчлан тусгана.

15 дугаар зүйл. Тусгай зөвшөөрөл

15.1 Дулаан хангамжийн байгууллага үйл ажиллагааны харгалзах чиглэлээр дулаан үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, зохицуулалттай хангах тусгай зөвшөөрлийг эрх бүхий байгууллагаас авна.

15.2 Энэ хуулийн 15.1-д заасан тусгай зөвшөөрлийг дараах нөхцөлд авах шаардлагагүй:

15.2.1 бие даасан дулаан хангамжийн систем ажиллуулах;

15.2.2 хэсэгчилсэн дулаан хангамжийн систем ажиллуулах.

15.3 Дулаан түгээх тусгай зөвшөөрлийг дараах шаардлагыг бүрэн хангасан этгээдэд олгоно:

15.3.1 дулааны эрчим хүч хэрэглэгчдийн тооцоот ачаалал 30 МВт-аас багагүй байх;

15.3.2 тухайн нэгдмэл нэг нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулах;

15.3.3 түгээх сүлжээг өөрийн өмчлөл, эзэмшилд бүртгэсэн байх.

15.4 Тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл гаргах, түүнийг шийдвэрлэх, тусгай зөвшөөрөл олгох эсэх асуудлыг Зөвшөөрлийн тухай хуулийн 5.1, 5.2, 5.3 дугаар зүйлээр зохицуулна.

15.5 Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 14.26, 14.27, 14.28, 14.32, 14.33 дэх хэсэгт заасан тусгай зөвшөөрөл авахад эрхлэх үйл ажиллагааны төрөлтэй уялдуулан өргөдөл дараах бичиг баримтаас хавсаргана:

15.5.1 техник, эдийн засгийн үндэслэл;

15.5.2 дулааны эрчим хүчийг үйлдвэрлэхэд ашиглах эрчим хүчний эх үүсгүүр, нөөцийн судалгаа;

15.5.3 үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, хангах дулааны эрчим хүчний төрөл, хэмжээ, чанарын үзүүлэлт;

15.5.4 үйл ажиллагаандaa ашиглах тоног төхөөрөмжийн үндсэн үзүүлэлт;

15.5.5 үйлчлэх хүрээ, эзэмшлийн зааг, дулааны эрчим хүчний үйлдвэрлэл, хангамж, хэрэглээний тэнцэл;

15.5.6 байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ;

15.5.7 байгаль орчныг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө;

15.5.8 тухайн хуулийн этгээдийн санхүү, хөрөнгийн нөөц, эдийн засгийн чадавх;

15.5.9 үйл ажиллагаагаа эхлэх хугацаа, хөрөнгө оруулалтын хэмжээ, санхүүжүүлэх эх үүсгүүр;

15.5.10 мэргэжлийн боловсон хучин, тэдгээрийн дадлага, туршлагын талаарх мэдээлэл.

15.6 Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сунгах, хүчингүй болгох асуудлыг Зөвшөөрлийн тухай хуулийн зохих зүйл заалтын дагуу шийдвэрлэнэ.

16 дугаар зүйл. Дулаан хангамжийн байгууллагын эрх, үүрэг

16.1 Дулаан үйлдвэрлэх байгууллага нь дараах эрх, үүрэгтэй байна:

16.1.1 энэ хуулийн нөхцөл шаардлагаас гадна тусгай зөвшөөрөл болон байгуулсан аливаа гэрээний нөхцөл шаардлагыг хангасан дулаан үйлдвэрлэх;

16.1.2 дулааны эх үүсгүүрийг дамжуулах, түгээх сүлжээнд холбох;

16.1.3 дулаан үйлдвэрлэх байгууллага нь дулаан худалдах үнэ, нөхцелийг дор дурдсанаас бусад тохиолдолд Зохицуулах хороогоор хянуулж батлуулах;

16.1.3.а. зөвхөн өөрийн болон өөрийн хамаарал бүхий этгээдийн хэрэгцээнд зориулж дулаан үйлдвэрлэх;

16.1.3.б. гэрээний үнээр харилцан тохиролцсон этгээдэд дулаан худалдах.

16.2 Дулаан дамжуулах байгууллага нь дараах эрх, үүрэгтэй байна:

16.2.1 хэрэглэгчийн дулааны хэрэглээг найдвартай хангахын тулд үйлдвэрлэсэн дулааныг түгээх сүлжээнд дамжуулах;

16.2.2 дамжуулах сүлжээг эзэмших, ашиглах, засвар үйлчилгээ хийх, шинэчлэх, сайжруулах, өргөтгөх;

16.2.3 дамжуулах сүлжээнд холбогдох холболтын журмыг боловсруулах, батлуулах, мөрдөх;

16.2.4 дулаан түгээх байгууллагыг тэгш эрхтэйгээр дамжуулах сүлжээнд холбогдох нөхцелийг бүрдүүлэх.

16.3 Дулаан түгээх байгууллага нь дараах эрх, үүрэгтэй байна:

16.3.1 дулаан түгээх байгууллага нь тусгай зөвшөөрөлд заасан дулаан хангамжийн бүсийн техникийн хүчин чадлын хүрээнд тухайн бүсийн бүх хэрэглэгчийг түгээх сүлжээнд эрх тэгш холбох;

16.3.2 тухайн дулаан хангамжийн бүсэд энэ хуульд заасан шаардлагыг хангасан хэрэглэгчийн тоноглолыг дулаан түгээх сүлжээнд холбох;

16.3.3 түгээх сүлжээнд холбогдох холболтын журмыг боловсруулах, батлуулах, мөрдөх;

16.3.4 эрх бүхий байгууллагаар баталгаажуулсан дулааны тоолуурыг холболтын цэгт түгээх сүлжээний шугам, тоног төхөөрөмж, тоноглолд суурилуулах;

16.3.5 хэрэглэгчийн дулааны хэрэглээг найдвартай хангахын тулд дамжуулсан дулааныг найдвартай түгээх;

16.3.6 түгээх сүлжээг эзэмших, ашиглах, засвар үйлчилгээ хийх, шинэчлэх, сайжруулах, өргөтгөх;

16.3.7 энэ хуулийн 10.2.7.6-д заасан холболтын журмын шаардлага хангасан хэрэглэгчтэй урьдчилан тохиролцсоны үндсэн дээр энэ хуулийн 23.1-д заасан гэрээг байгуулж, тухайн хэрэглэгчийн шугамаас бусад хэрэглэгчийг холбох.

16.4 Хэрэглэгчийн дулааны төлбөр тооцох тоолуур нь дулаан түгээх тусгай зөвшөөрөл эзэмшигчийн өмч байж болно.

16.5 Дулаан түгээх тусгай зөвшөөрөл эзэмшигч нь дулаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрөл эзэмшигч байна.

16.6 Дулаан борлуулах (хангах) байгууллага нь дараах эрх, үүрэгтэй байна:

- 16.6.1 дулаан үйлдвэрлэх, дамжуулах байгууллагатай хүрэлцээтэй хэмжээний дулааны чадал авах тухай тохиролцох;
- 16.6.2 дулаан дамжуулах үйлчилгээний төлбөрийг төлөх;
- 16.6.3 энэ хуулийн 10.2.7.а-д заасан аж ахуйн харилцааны дурмийг мөрдөх;
- 16.6.4 дулаан борлуулах (хангах) байгууллага нь өөрийн тусгай зөвшөөрөлд заасан дулаан хангамжийн бүс дэх зарим хэрэглэгчийн дулааны борлуулалтыг иргэн, хуулийн этгээдтэй байгуулсан гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж болно. Гэрээт борлуулагчид худалдах үнэ, төлөх шимтгэлийг хоорондын гэрээгээр тохиролцох ба хэрэглэгчид энэ хуульд заасны дагуу тогтсон үнэ, тарифаар худалдана.

16.7 Энэ хуулийн 16.1, 16.2, 16.3, 16.6-д заасан эрх, үүргээс гадна тусгай зөвшөөрлийн төрлөөс үл хамааран дараах нийтлэг үүргийг хүлээнэ:

- 16.7.1 тусгай зөвшөөрлийг бусдад шилжүүлэхгүй байх;
- 16.7.2 хууль тогтоомж, эрчим хүчний техникийн ашиглалт, аюулгүй ажиллагааны дүрэм, журам, тусгай зөвшөөрөлд заасан нөхцөл, шаардлага, тусгай зөвшөөрөл олгогчийн шийдвэрийг дагаж мөрдөх;
- 16.7.3 санхүүгийн тайлан бүртгэлийг тусгай зөвшөөрөл олгосон үйл ажиллагааны төрөл тус бүрээр, тусгай зөвшөөрөлд хамаarahгүй үйл ажиллагааны тайлан бүртгэлээс тусад нь хөтлөх;
- 16.7.4 аудитын байгууллагаар баталгаажуулсан санхүүгийн тайланг тусгай зөвшөөрөл олгогчид жил бүр гаргаж өгөх;
- 16.7.5 нэгдсэн сүлжээ, төвлөрсөн дулаан хангамжийн дурмийн дагуу дулааны эрчим хүчийг үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, борлуулах (хангах);
- 16.7.6 энэ хуулийн 10.2.2-д заасан нөхцөл байдал үүссэн тохиолдолд тусгай зөвшөөрөл олгогчид мэдэгдэх, зөвшөөрөл авах;
- 16.7.7 тусгай зөвшөөрөл олгогчийн эрх бүхий ажилтнаас эрх хэмжээнийхээ хүрээнд тавьсан шаардлагыг биелүүлэх, өөрийн байр, байгууламжид нэвтрүүлэх, ажил үүргээ биелүүлэх нөхцөлөөр хангах;
- 16.7.8 тусгай зөвшөөрөл эзэмшигчийн техник, эдийн засгийн үйл ажиллагаанд үнэлгээ өгөхөд шаардлагатай мэдээллийг тусгай зөвшөөрөл олгосон байгууллагын шаардсанаар цаг тухайд нь үнэн зөвөөр гаргаж өгөх;
- 16.7.9 дулаан дамжуулах, түгээх байгууллага нь дулаан дамжуулах, түгээх сүлжээг шинэчлэх, сайжруулах, өргөтгөх талаар 3-5 жилийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг боловсруулахдаа харилцагч бусад дулаан хангамжийн байгууллагын саналыг авч, тусгай зөвшөөрөл олгогчид жил бүр тодотгож, мэдэгдэх;
- 16.7.10 үйл ажиллагаагаа дулааны хангамжид нөлөө үзүүлэхүйц байдлаар тодорхой хугацаагаар зогсоох шаардлагатай бол тусгай зөвшөөрөл олгогчид 6-

аас доошгүй сарын өмнө мэдэгдэх;

16.7.11 үйл ажиллагаагаа эхлэхээс өмнө байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг эрх бүхий байгууллагаар хийлгэх, байгаль хамгаалах, нөхөн сэргээх жил бүрийн төлөвлөгөө боловсруулж, холбогдох байгууллагаар батлуулж, мөрдөх;

16.7.12 холбогдох дүрэм, журам, норм, стандарт, тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг хангаж ажиллах, үйл ажиллагаагаа технологийн горимын дагуу аюулгүй, техникийн өндөр түвшинд явуулах.

17 дугаар зүйл. Дулаан хангамжийн байгууллага хоорондын гэрээ

17.1 Дулаан хангамжийн байгууллага хоорондын харилцаа дараах гэрээгээр зохицуулагдана:

17.1.1 дулаан үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, хангах тусгай зөвшөөрөл эзэмшигчид хоорондоо дулааны эрчим хүч худалдах, худалдан авах гэрээ байгуулна;

17.1.2 дулаан үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, хангах үйл ажиллагааг нэг байгууллага хариуцаж байгаа тохиолдолд энэ хуулийн 17.1.1-д заалтад заасан гэрээг байгуулахгүй.

17.2 Төвлөрсөн дулаан хангамжийн системийн хүрээнд дулаан хангамжийн байгууллага хоорондын харилцааг зохицуулсан гэрээ нь загвар гэрээний үндсэн дээр хийгдэнэ.

17.3 Энэ хуулийн 17.2-т заасан загвар гэрээг Зохицуулах хороо батална.

17.4 Дулааны эрчим хүч худалдах, худалдан авах гэрээнд дараах зүйлсийг заавал тусгана:

17.4.1 нийлүүлэх дулааны чанар, сард нийлүүлэх захиалгат тоо хэмжээ;

17.4.2 сүлжээний нэмэлт усны тооцоо, төлбөрийн нөхцөл;

17.4.3 үйлчилгээ үзүүлэх нөхцөл;

17.4.4 талуудын эрх, үүрэг, хариуцлага;

17.4.5 маргаан шийдвэрлэх;

17.4.6 гэрээний хугацаа, дуусгавар болгох нөхцөл;

17.4.7 бусад шаардлагатай нөхцөл.

17.5 Дулааны эрчим хүч худалдах, худалдан авах гэрээг жил бүр дүгнэж, гэрээ дүгнэсэн акт үйлдэнэ.

ТАВДУГААР БҮЛЭГ. ДУЛААН ХАНГАМЖИЙН СИСТЕМ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

18 дүгээр зүйл. Дулаан хангамжийн системийн ангилал

18.1 Дулаан хангамжийн систем нь төвлөрсөн, хэсэгчилсэн, бие даасан дулаан хангамжийн систем гэсэн ангилалтай байна.

18.2 Хотын Захирагч, аймгийн Засаг дарга нь өөрийн харьяаллын нутаг дэвсгэрт хуульд заасан ангиллаар дулаан хангамжийн системийн төлөвлөлтийг хийх ба

дулаан хангамжийн хөгжлийн төлөвлөгөө (схем)-нд тусгаж шийдвэрлэнэ.

18.3 Хот, суурин газрын төвлөрсөн дулаан хангамжийн системд холбогдох боломжгүй, газар зүйн хувьд төвөгшил ихтэй, алслагдсан байршилд тухайн хот, суурин газрын нийт хэрэглээний цөөнхийг хангах, суурилагдсан хүчин чадал нь 10 МВт-аас бага системийг төвлөрсөн дулаан хангамжийн системээр хангахгүй байж болно.

18.4 Төвлөрсөн дулаан хангамжийн системийн дулаан дамжуулах шугам, дэд станц нь төрийн өмчлөлд байна.

18.5 Төр, орон нутгийн байгууллага нь техник, эдийн засгийн хувьд үр ашигтай, хэрэглэгчийн хэрэгцээнд дулааны эрчим хүч бий болгох бодит өртөг хамгийн бага байх нөхцөлийг шалгуур болгон төвлөрсөн дулаан хангамжийн системийг дэмжих шийдвэрийг дараах баримт бичгүүдийг боловсруулахдаа тусгах үүрэгтэй:

18.5.1 хууль эрх зүйн акт боловсруулах, батлах;

18.5.2 урт ба дунд хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг болон бусад хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулах, батлах;

18.5.3 дулаан хангамжийн хөгжлийн төлөвлөгөө (схем) болон хот байгуулалт, төлөвлөлтийн бусад баримт бичиг боловсруулах, батлах;

18.5.4 өөрийн бүрэн эрхийнхээ хүрээнд бусад шийдвэр, акт гаргах.

19 дугаар зүйл. Төвлөрсөн дулаан хангамжийн систем

19.1 Төвлөрсөн дулаан хангамжийн системийн оролцогчид нь энэ системд үйл ажиллагаа явуулдаг дулааны хангамжийн байгууллагууд байна.

19.2 Төвлөрсөн дулаан хангамжийн систем дэх дулаан үйлдвэрлэгч нь үйлдвэрлэсэн дулаанаа түгээх байгууллага, шууд холбогдсон хэрэглэгчдэд борлуулна.

19.3 Төвлөрсөн дулаан хангамжийн систем дэх дулаан дамжуулах, түгээх байгууллага нь дулаан (дулаан зөөгч)-ыг дамжуулан, түгээж хэрэглэгчдэд борлуулна.

19.4 Төвлөрсөн дулаан хангамжийн системийн дулаан хангамжийн байгууллагууд дараах эрхтэй байна:

19.4.1 тухайн дулаан хангамжийн бүсийн системийн техникийн хүчин чадал хүрэлцээгүй эсхүл өмнө холбогдсон хэрэглэгчдийн дулаан хангамжийн аюулгүй, найдвартай байдалд эрсдэл учруулах тохиолдолд шинэ холболт хийхээс татгалзах ба татгалзсан үндэслэл тайлбарыг өгөх;

19.4.2 төвлөрсөн дулаан хангамжийн системд зөвшөөрөлгүй холболт хийсэн мөн хуульд заасан бусад тохиолдолд дулааны борлуулалтыг хязгаарлах эсхүл зогсоох;

19.4.3 хэрэглэгчийн тоноглолд болон түгээх сүлжээний арилжааны тоолуурт үзлэг хийх;

19.4.4 хэрэглэгчийн тоноглолын доголдоос үүдэн дулаан хангамжийн технологийн үйл явц тасалдсан тохиолдолд үүссэн хохирлыг нөхөн төлүүлэхийг шаардах.

19.5 Төвлөрсөн дулаан хангамжийн системийн дулаан хангамжийн байгууллагууд дараах үүрэгтэй байна:

- 19.5.1 техникийн хүчин чадал хүрэлцээтэй тохиолдолд шинэ хэрэглэгчийг холбох, түүний техникийн нөхцөлийг олгох;
- 19.5.2 шинэ хэрэглэгчийг холбох эрх тэгш нөхцөлийг хангах;
- 19.5.3 тухайн дулаан хангамжийн бүсийн төвлөрсөн дулаан хангамжийн системд холбогдсон бүх хэрэглэгчдэд хууль тогтоомж, байгуулсан гэрээний дагуу зохих чанар, тоо хэмжээгээр дулаанаар хангах (борлуулах);
- 19.5.4 хэрэглэгчдэд нийлүүлж буй дулааны чанар, тоо хэмжээг бүртгэх, зөрчлийг хянах, түүнээс урьдчилан сэргийлэх, арилгах арга хэмжээг цаг тухайд нь авах;
- 19.5.5 салбарын хууль тогтоомж, байгуулсан гэрээнд заасан тохиолдлоос бусад тохиолдолд дулааны үйлдвэрлэлийг тасалдуулахгүй байх;
- 19.5.6 салбарын хууль тогтоомж, байгуулсан гэрээний дагуу дулаан хангамжийн чанар, найдвартай байдлыг хангах;
- 19.5.7 дулаан хангамжийн арилжааны тоолуурын техникийн хэвийн ажиллагаа, ашиглалтын үеийн аюулгүй байдлыг хангах;
- 19.5.8 дулаан хангамжийн бүсийн жилийн үйлдвэрлэлийн хэмжээ нь 10,000 МВт.цаг-аас багагүй дулаан хангамжийн байгууллага нь хуанлийн долоо хоногийн туршид дулааныг үйлдвэрлэхэд хэрэглэх түлшний нөөцтэй байх;
- 19.5.9 түлш нөөцлөх хэмжээг өмнөх жилийн нэг өдрийн хамгийн их хэрэглээн дээр үндэслэж тодорхойлох;
- 19.5.10 салбарын хууль тогтоомж, байгуулсан гэрээний дагуу хэрэглэгчдэд учирсан хохирлыг нөхөн төлөх;
- 19.5.11 дулааны тариф өөрчлөгдсөн тохиолдолд хууль тогтоомж, байгуулсан гэрээнд заасан хугацаа, журмын дагуу хэрэглэгчдэд мэдэгдэх;
- 19.5.12 салбарын хууль тогтоомж, техникийн норм, стандартын дагуу дулаан хангамжийн систем, дулааны барилга байгууламж, дулааны сүлжээ болон бусад эд хөрөнгийг зохих түвшинд, хэвийн ажиллуулах;
- 19.5.13 дулааны чиглэлээр үйл ажиллагаа явуулахад ашиглаж буй эд хөрөнгөд засвар, үйлчилгээ хийх, шинэчлэх, сайжруулах, өргөтгөх шаардлагатай байгаа талаар эд хөрөнгийн өмчлөгч болон бусад сонирхогч талуудад цаг тухайд нь мэдэгдэх;
- 19.5.14 салбарын хууль тогтоомж, дулаан хангамжийн байгууллагын дотоод баримт бичигт заасны дагуу аваар, ослын улмаас дутуу нийлүүлсэн дулааны тоо хэмжээ, чадлын зөрчлийн талаар өмчлөгч болон бусад сонирхогч талуудад мэдэгдэх;
- 19.5.15 энэ хууль болон холбогдох, дүрэм, журам, норм, стандартын дагуу эрчим хүчний мэргэжлийн хяналтын байгууллага, хэрэглэгчдэд аваар, технологийн зөрчлийн улмаас дулаан хангамж тасалдсан, доголдсон талаар мэдэгдэх;

19.5.16 халаалтын улиралд бэлэн байгаа эсэхийг баталгаажуулах, бэлэн байдлын тайланг эрх бүхий байгууллагад гаргаж өгөх;

19.5.17 салбарын мэдээллийн нэгдсэн системийг журмын дагуу ашиглах, шаардлагатай мэдээллийг холбогдох санд бүртгэх;

19.5.18 эрх бүхий байгууллагаас тогтоосон журмын дагуу мэдлэг, мэргэшлийн сонгон шалгаруулалт, шалгалтад тэнцсэний дараа дулаан үйлдвэрлэх, дамжуулах, түгээх байгууллагын дарга, ерөнхий инженер болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан даргыг томилох;

19.5.19 инженер техникийн ажилтнууд, мэргэжилтэй ажилчдыг мэдлэг, мэргэшлийн шалгалтад тэнцсэн эсэхийг баталгаажуулах, түүний үндсэн дээр ашиглалт, засвар үйлчилгээ, тохироулга, угсралтын үйл ажиллагаа явуулах, дулааны барилга байгууламж, дулаан дамжуулах, түгээх сүлжээ, тоног төхөөрөмжийг эрх бүхий байгууллагаас тогтоосон журмын дагуу шалгах, үзлэг хийх эрх олгох.

19.6 Төвлөрсөн дулааны сүлжээнд холбогдсон хэрэглэгч дараах эрхтэй байна:

19.6.1 энэ хуульд холбох боломжгүй гэж зааснаас бусад аль ч тохиолдолд дулааны сүлжээнд холбогдох техникийн нөхцөлийг авах;

19.6.2 техникийн нөхцөлийн дагуу дулааны сүлжээнд холбогдох;

19.6.3 зохих чанар, too хэмжээтэй дулаанаар хангагдах;

19.6.4 техникийн боломжийг харгалзан, гэрээний нөхцөлийн дагуу дулааны хэрэглээг өөрөө тохироулах;

19.6.5 дулаан хангамжийн тоо хэмжээ, чанар, үнэ, тариф, төлбөрийн журам, дулааны хэрэглээний горим, дулааны эх үүсгүүр, түүний тоног төхөөрөмж, дулааны сүлжээ, тэдгээрийг засварлах, шинэчлэх, сайжруулах, өргөтгөх, эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх, дулаан алдагдлыг бууруулахад авч хэрэгжүүлэх арга хэмжээ болон энэ хууль, холбогдох дүрэм, журам, байгуулсан гэрээнд заасан бусад мэдээллийг дулаан хангамжийн байгууллагаас авах;

19.6.6 хууль тогтоомжийн дагуу дулаан хангамжийн байгууллага гэрээний нөхцөлийг зөрчсөн, дулааны too хэмжээ, чанар хангагдаагүйн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх.

19.7 Төвлөрсөн дулаан хангамжийн системд холбогдсон хэрэглэгч дараах үүрэгтэй байна:

19.7.1 дулааны сүлжээнд холбогдох техникийн нөхцөлийг биелүүлэх;

19.7.2 дулаан түгээх байгууллагатай дулаан хангамж (борлуулалт)-ийн гэрээ байгуулах;

19.7.3 өөрийн дулаан хангамжийн арилжааны тоолуурын хэвийн, аюулгүй ажиллах орчин нөхцөлийг бүрдүүлэх;

19.7.4 гэрээнд заасан тохиолдолд дулааны хэрэглээний горимыг мөрдөх;

19.7.5 гэрээний нөхцөл болон тогтоосон тариф эсхүл тохиролцсон үнийн дагуу дулааны хангамжийн үйлчилгээний төлбөрийг төлэх;

19.7.6 нийтийн орон сууцны дотор дулааны сүлжээний схемийг өөрчлөх тохиолдолд нийт өмчлөгчдийн гуравны хоёрын гарын үсэгтэй зөвшөөрлийг авч, дулаан хангамжийн системийг шинэчлэх төслийг боловсруулан хэрэгжүүлэх;

19.7.7 нийтийн орон сууц эсхүл орон сууцны бус барилгын дулааны дотор системийг өөрчлөх тохиолдолд дулаан түгээх байгууллагатай зураг төслийг урьдчилан зөвшилцэх;

19.7.8 нийтийн орон сууцны дундын өмчлөлд хамаарах хэсгүүдэд эрх бүхий байгууллагаас баталсан журмын дагуу эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх, дулааны алдагдлыг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх, үүнд шаардагдах зардлыг орон сууцны өмчлөгчид хамтран хариуцах;

19.7.9 дулааны тоолуур эвдэрсэн болон дулааны хэрэглээний горим зөрчигдсөн талаар дулаан хангамжийн байгууллагад шуурхай мэдээлэх.

19.8 Төвлөрсөн дулааны сүлжээнд зөвшөөрөлгүй холболт хийхийг хориглоно.

20 дүгээр зүйл. Хэсэгчилсэн дулаан хангамжийн систем

20.1 Хэсэгчилсэн дулаан хангамжийн системийн оролцогч талуудын харилцаа дараах заалтуудаар зохицуулагдана:

20.1.1 тухайн дулаан хангамжийн системийн оролцогчдыг системийн өмчлөгч тодорхойлох ба тэдгээр нь энэ хуульд заасны дагуу гэрээ байгуулна;

20.1.2 тухайн дулааны сүлжээнд өмчлөгчийн зөвшөөрөлгүй холболт хийхийг хориглоно;

20.1.3 тухайн байршил, нутаг дэвсгэрт дулааны шинэ ачаалал үүсэж, дулаан хангамжийн системийн суурилагдсан хүчин чадал 10 МВт-аас нэмэгдсэн нөхцөлд Зохицуулах хороонд мэдэгдэж, дулаан хангамжийн системийн ангиллын бүртгэлийг өөрчлүүлнэ;

20.1.4 энэ хуулийн 20.1.3-т заасны дагуу дулаан хангамжийн системийн ангилал өөрчлөгдсөн бол тухайн байршил, нутаг дэвгэрт энэ хуулийн 19.4, 19.5, 19.6, 19.7 заалтад заасан төвлөрсөн дулаан хангамжийн нийтлэг зохицуулалт үйлчилнэ.

20.2 Энэ зүйлд хамаарах дулаан хангамжийн системийн дулаан хангамжийн байгууллага дараах эрхтэй байна:

20.2.1 дулаан хангамжийн системд зөвшөөрөлгүй холболт хийсэн мөн энэ хуульд заасан тохиолдолд дулаан хангамж (борлуулалт)-ийг хязгаарлах буюу зогсоох;

20.2.2 хэрэглэгчийн дулааны тоолуурын заалт, ажиллагаатай танилцах;

20.2.3 тухайн дулаан хангамжийн системд харилцан тохиролцож холбогдох, загвар гэрээний дагуу холбох гэрээ байгуулах.

20.3 Энэ зүйлд хамаарах дулаан хангамжийн системийн дулаан хангамжийн байгууллага дараах үүрэгтэй байна:

20.3.1 энэ хуулийн 41.2-р зүйлд заасан тохиолдолд хэрэглэгчидтэй загвар гэрээний үндсэн дээр гэрээ байгуулах;

- 20.3.2 дулааныг зохих чанар, тоо хэмжээгээр борлуулах;
- 20.3.3 дулаан хангамжийн найдвартай байдал, чанарыг хангах;
- 20.3.4 дулаан хангамжийн арилжааны тоолуурын техникийн хэвийн ажиллагаа, ашиглалтын үеийн аюулгүй байдлыг хангах;
- 20.3.5 дулааны үйлчилгээний тариф болон үнийн өөрчлөлтийн талаар хэрэглэгчдэд хууль тогтоомж болон гэрээнд заасан хугацаа, журмын дагуу мэдээлэх;
- 20.3.6 дулаан хангамжийн систем, дулааны барилга байгууламж, тоног төхөөрөмж болон бусад эд хөрөнгөд зохих ёсоор засвар үйлчилгээ хийх, сайжруулах, шинэчлэх, өргөтгөх, найдвартай ажиллуулах;
- 20.3.7 технологийн зөрчил, ослын талаар орон нутгийн захиргааны байгууллага болон хэрэглэгчдэд хуульд заасан журмын дагуу мэдээлэх;
- 20.3.8 халаалтын улирлын бэлэн байдлыг хангах, бэлэн байдлын тайланг эрх бүхий байгууллагад хүргүүлэх;
- 20.3.9 хэрэглэгчдэд гэрээ болон хууль тогтоомжид заасны дагуу учирсан хохирлыг нөхөн төлөх;
- 20.3.10 салбарын мэдээллийн нэгдсэн систем, санг журмын дагуу ашиглах.

20.4 Энэ зүйлд хамаарах дулаан хангамжийн системийн хэрэглэгч дараах эрхтэй байна:

- 20.4.1 дулаан хангамжийн байгууллагатай загвар гэрээний үндсэн дээр гэрээ байгуулах;
- 20.4.2 зохих чанар, тоо хэмжээгээр дулаанаар хангагдах;
- 20.4.3 техникийн боломжийг харгалзан эсхүл гэрээний дагуу дулааны хэрэглээгээ өөрөө тохируулах;
- 20.4.4 энэ хуулийн 30.1-р зүйлд заасан тохиолдолд тогтоосон тарифын дагуу, эсхүл гэрээнд заасан үнээр дулаан хангамжийн үйлчилгээг авах;
- 20.4.5 дулаан хангамжийн байгууллагаас дулаан хангамжийн чанар, тариф болон үнэ, төлбөрийн журам, дулааны хэрэглээний төрөл, тоног төхөөрөмжийн байдал, засвар үйлчилгээ, сайжруулалт, шинэчлэл, өргөтгөл болон эрчим хүчиний үр ашгийг дээшлүүлэх талаар мэдээлэл авах;
- 20.4.6 гэрээний нөхцөл зөрчигдсөн болон дулаан хангамжийн чанар, тоо хэмжээ хангагдаагүйн улмаас үүссэн хохирлыг нөхөн төлүүлэх;
- 20.4.7 гэрээ болон гэрээний төслөөс хууль тогтоомж зөрчсөн заалтуудыг хасахыг дулаан хангамжийн байгууллагаас шаардах.

20.5 Энэ зүйлд хамаарах дулаан хангамжийн системийн хэрэглэгч дараах үүрэгтэй байна:

- 20.5.1 энэ хуулийн 41.2 зүйлд заасан тохиолдолд дулаан хангамжийн байгууллагатай загвар гэрээ байгуулах;
- 20.5.2 өөрийн дулаан хангамжийн арилжааны тоолуурын хэвийн, аюулгүй ажиллах орчин нөхцөлийг бүрдүүлэх;

- 20.5.3 гэрээнд заасан дулааны хэрэглээний горимыг мөрдөх;
- 20.5.4 дулаан хангамжийн үйлчилгээний төлбөрийг гэрээний нөхцөл болон тогтоосон тариф, эсхүл тохиролцсон үнийн дагуу төлөх;
- 20.5.5 хэрэглэгчийн тоноглол болон тоолуурт дулаан хангамжийн байгууллага болон орон нутгийн захиргааны байгууллагуудын төлөөлөгчид нэвтрэх, хянах, шалгах боломжийг бүрдүүлэх;
- 20.5.6 нийтийн орон сууцны дундын өмчлөлд хамаарах хэсгүүдэд эрх бүхий байгууллагаас баталсан журмын дагуу эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх, дулааны алдагдлыг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх, үүнд шаардагдах зардлыг хуваалцах;
- 20.5.7 нийтийн орон сууцны нийтийн эзэмшлийн талбайг халаасан дулаан хангамжийн үйлчилгээний төлбөрийг журмын дагуу төлөх үүрэгтэй.

21 дугаар зүйл. Бие даасан дулаан хангамжийн систем

- 21.1 Бие даасан дулаан хангамжийн системийг барих, бий болгоход ямар нэгэн зөвшөөрөл шаардахгүй.
- 21.2 Бие даасан дулаан хангамжийн системд суурилуулсан эх үүсгүүр, сүлжээ, тоног төхөөрөмж нь техник технологийн, байгаль орчныг хамгаалах хууль тогтоомжийн шаардлага болон норм, стандартыг хангасан байна.
- 21.3 Сэргээгдэх эрчим хүчний эх үүсгүүр ашигласан, хүлэмжийн хийн ялгарал багатай бие даасан дулаан хангамжийн системийг бодлогоор дэмжиж, хөгжлийн бодлого, төлөвлөлт болон дулаан хангамжийн хөгжлийн төлөвлөгөө (схем)-д хэрхэн дэмжих талаар дэлгэрэнгүй зохицуулалтыг эрх бүхий этгээд тусгах үүрэгтэй.
- 21.4 Тухайн орон нутгийн дулаан хангамжийн онцлог, хөгжлийн бодлого, төлөвлөлт, дулаан хангамжийн хөгжлийн төлөвлөгөө (схем)-тэй нийцүүлж бие даасан дулаан хангамжийн системд үзүүлэх бодлогын болон санхүүгийн дэмжлэгийг эрх бүхий этгээд тухай бүр төлөвлөж, хэрэгжүүлнэ.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ. ДУЛААНЫ СҮЛЖЭЭНИЙ ХОЛБОЛТ

22 дүгээр зүйл. Сүлжээнд шинээр холбох

- 22.1 Дулаан дамжуулах эсхүл түгээх байгууллага нь өөрийн дулаан хангамжийн бүсийн хүрээнд хамрах шинээр холбогдох хүсэлт гаргасан (цаашид “хүсэлт гаргагч” гэх) аливаа этгээдийг тухайн холболт нь өмнөх холбогдсон хэрэглэгчийн дулаан хангамжийн найдвартай байдалд аюул учруулахгүй тохиолдолд техникийн хүчин чадалдаа тулгуурлан сүлжээндээ холбох үүрэгтэй.
- 22.2 Дулаан дамжуулах эсхүл түгээх байгууллага нь шинэ холболтын хүсэлт хүлээн авах, шийдвэрлэх цахим системтэй байна.
- 22.3 Сүлжээнд шинээр холбогдох боломжтой хэсэг, хүчин чадлын мэдээллийг ил тод нийтэлсэн байна.
- 22.4 Нийтийн орон сууцны барилгын хувьд дулааны сүлжээнд холбогдох хүсэлт гаргагч нь тухайн барилгыг барьж буй барилгын компани эсхүл сууц өмчлөгчдийн холбоо байна. Хэрэв нийтийн орон сууцны хувьд аль нэг айл нь дангаараа дулааны

сүлжээнд холбогдох техникийн боломжтой бол тухайн айл нь дулааны сүлжээнд холбогдох хүсэлт гаргагч байж болно.

22.5 Дулаан дамжуулах эсхүл түгээх байгууллага нь холболтын хүсэлт хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор сүлжээнд холбох техникийн нөхцөл (цаашид “техникийн нөхцөл” гэх)-ийг олгох ба хэрэв татгалзсан тохиолдолд татгалзах болсон үндэслэл, шалтгааныг тодорхой заасан хариуг бичгээр өгнө.

22.6 Дулаан дамжуулах, түгээх байгууллага нь холболтын техникийн нөхцөлийг энэ хуулийн 22.1-д зааснаас өөр үндэслэл, шалтгаанаар олгохоос татгалзахыг хориглоно.

22.7 Техникийн нөхцөл нь дараах шаардлагад нийцсэн байна:

- 22.7.1 ил тод, ойлгомжтой, хоёрдмол утгагүй байх;
- 22.7.2 ижил нөхцөлд холбогдох хүсэлт гаргагчид эрх тэгш хандах зарчмыг баримтлах;
- 22.7.3 холболт тус бүрийн техникийн болон эдийн засгийн нөхцөлийг харгалзан үзэх;
- 22.7.4 сүлжээний цаашдын хөгжил, тогтвортой байдлыг харгалзан үзэх;
- 22.7.5 сүлжээнд холбогдсон бусад хэрэглэгчийн аюулгүй, найдвартай байдлыг хангах боломжийг харгалзан үзэх;
- 22.7.6 сүлжээний техникийн хүчин чадлыг харгалзан үзэх.

22.8 Техникийн нөхцөлд дараах зүйлүүдийг тусгана:

- 22.8.1 холболтын цэг;
- 22.8.2 тоолуурын байршил;
- 22.8.3 шугам, сүлжээний өмчлөл, эзэмшлийн зааг;
- 22.8.4 холбогдох хүсэлт гаргагч болон дамжуулах эсхүл түгээх байгууллагын үүрэг;
- 22.8.5 холболтын төлбөрийн тооцоолол;
- 22.8.6 холболтын нөхцөлийн хүчинтэй байх хугацаа;
- 22.8.7 бусад нөхцөлүүд.

22.9 Энэ хуульд зааснаар сүлжээнд холбогдсон хэрэглэгчийн шугам, тоноглол болон түүний аль нэг хэсэг солигдсон эсхүл эзэмшигч өөрчлөгдсөн бөгөөд дараах нөхцөлүүд нэгэн зэрэг хангагдсан тохиолдолд сүлжээний шинэ холболт гэж үзэхгүй бөгөөд холболтын төлбөрийг эзэмшигчээс авахгүй:

- 22.9.1 холболтын цэгийн байршил өөрчлөгдөхгүй байх;
- 22.9.2 техникийн нөхцөлд өөрчлөлт оруулах шаардлагагүй байх;
- 22.9.3 холболтын техникийн нөхцөл хүчинтэй байх.

23 дугаар зүйл. Холболтын гэрээ

23.1 Хүсэлт гаргагч сүлжээнд холбогдохын тулд дулаан дамжуулах, түгээх байгууллагатай холболтын гэрээ (цаашид “холболтын гэрээ” гэх)-г бичгээр

байгуулна.

23.2 Холболтын гэрээнд дараах зүйлийг тусгана:

- 23.2.1 холболтын цэг;
- 23.2.2 тоолуурын байршил;
- 23.2.3 сүлжээний өмчлөл, эзэмшлийн зааг;
- 23.2.4 холболтын төлбөр;
- 23.2.5 холболтын техникийн нөхцөл;
- 23.2.6 гэрээний хугацаа.

23.3 Дамжуулах, түгээх сүлжээнд холболтын гэрээний дагуу холбогдохоос өмнө, сүлжээнээс салангид хийгдэх шугам, сүлжээ, барилга байгууламж барих угсралтын ажил нь өрсөлдөөнт ажил үйлчилгээ байх бөгөөд уг ажлыг дулаан хангамжийн байгууллага гүйцэтгэхийг хориглоно.

23.4 Дулаан хангамжийн байгууллага нь энэ хуулийн 23.3-т заасан ажилд магадлал хийх, угсралтын ажилд хяналт тавих чиг үүрэгтэй оролцох бөгөөд ажлын гүйцэтгэлд хяналт тавих хуваарь, төлбөрийг холболтын гэрээнд тусгаж, хэрэгжүүлнэ.

23.5 Дулаан хангамжийн байгууллагын гаргасан холболтын хүсэлтийг хүлээн авахаас татгалзах, холболтын төлбөрийг тодорхойлох болон холболтын гэрээний нөхцөл, шаардлагыг тогтоохтой холбоотой шийдвэр нь үндэслэлтэй эсэхийг Эрчим хүчний зохицуулах хороо хянан шалгах эрхтэй.

23.6 Холболтын гэрээ нь дулаан худалдах, худалдан авах, дулаанаар хангах гэрээ байгуулах үндэслэл болно.

24 дугаар зүйл. Холболтын төлбөр тооцох

24.1 Дулаан дамжуулах, түгээх байгууллага нь хүсэлт гаргагчийг дулааны сүлжээнд холбоходо холболтын төлбөр авна. Холболтын төлбөр нь энэ хуульд заасны дагуу тооцсон үндэслэл бүхий төлбөр байна.

24.2 Холболтын төлбөрийг холболт бүрд дараах нөхцөлийг хангахуйц байхаар тооцно:

- 24.2.1 шаардлагатай хөрөнгө оруулалтыг нөхөх;
- 24.2.2 сүлжээнд холбогдох хүчин чадал, байршилаас хамаарах;
- 24.2.3 нэгж хүчин чадалд ногдох төлбөрт үндэслэх;
- 24.2.4 хүсэлт гаргагч тухайн сүлжээний хөрөнгө оруулалтын зардлын өөрийн хүчин чадалд ногдох хэсгийг төлөх;
- 24.2.5 хэрэглэгчийн холболтын төлбөрөөр хариуцах зардал нь сүлжээний тодорхой цэгээр хязгаарлагдах.

24.3 Холболтын төлбөрийг дулаан дамжуулах, түгээх байгууллага тооцож гаргана.

24.4 Холболтын техникийн нөхцөлийг дулаан дамжуулах, түгээх байгууллагын санаачилгаар өөрчилсөн тохиолдолд холбогдох зардлыг тухайн байгууллага хариуцна.

24.5 Хэрэв хэрэглэгчийн санаачилгаар техникийн нөхцөлд өөрчлөлт орсон тохиолдолд үүнтэй холбогдон гарах зардлыг тухайн хүсэлт гаргагчаас дулаан хангамжийн байгууллага холболтын төлбөр дээр нэмж гаргуулна.

25 дугаар зүйл. Хувийн өмчлөлийн сүлжээ

25.1 Хүсэлт гаргагчийг төвлөрсөн дулааны сүлжээнд холбогдоход дулааны сүлжээг шинээр барьж байгуулах шаардлагатай тохиолдолд өөрийн хөрөнгөөр барьж байгуулж болно.

25.2 Хувийн өмчлөлийн сүлжээний ашиглалт, үйлчилгээг мэргэжлийн байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж болно.

25.3 Хувийн өмчлөлийн сүлжээнд тухайн сүлжээг өмчлөгчөөс гадна дараагийн хэрэглэгч холбогдох нөхцөлд уг сүлжээ нь нийтийн сүлжээ болж дулаан түгээх байгууллагын өмчлөлд шилжүүлнэ.

25.4 Өөрийн өмчлөлийн сүлжээндээ дараагийн хэрэглэгч холбох эсэх асуудлыг шугам сүлжээг өмчлөгч шийдэх эрхтэй.

25.5 Энэ хуулийн 25.3-т заасны дагуу хувийн өмчлөлийн сүлжээг шилжүүлсэн тохиолдолд тухайн сүлжээнд холбогдож буй шинэ хэрэглэгчээс сүлжээнд эзлэх хувь хэмжээнд нь дүйцүүлж тооцсон холболтын төлбөрийг гаргуулж анхны хөрөнгө оруулагчид олгох замаар оруулсан хөрөнгө оруулалтыг нөхнө.

26 Холболтын журам

26.1 Энэ хуулийн 22, 23, 24, 25 дугаар зүйлд заасан зохицуулалтуудыг хангасан холболтын журмыг Эрчим хүчний зохицуулах хороо батална.

26.2 Дулаан хангамжийн байгууллага нь холболтын журмын төслийг боловсруулах, өөрчлөлт оруулах, шинэчлэх талаар санал гаргах эрхтэй.

ДОЛООДУГААР БҮЛЭГ. ТООЛУУР, ТООЛУУРЫН СИСТЕМ

27 дугаар зүйл. Тоолуур суурилуулах

27.1 Дулааны эрчим хүчийг тоолуур эсхүл дулааны зардал хуваарилах төхөөрөмж ашиглан тооцно. Шинээр холбогдох хэрэглэгчийн техникийн нөхцөлд дулааны тоолууртай байх нөхцөл, техникийн шаардлагыг заавал тусгаж өгнө.

27.2 Дулааны эрчим хүчийг зардал хуваарилах төхөөрөмж ашиглан хуваарилах, тооцох журмыг Эрчим хүчний зохицуулах хороо батална.

27.3 Төвлөрсөн дулаан хангамжийн системд шинээр ашиглалтад орж буй нийтийн орон сууцны барилгад нийтийн болон орон сууцны хэмжих хэрэгслийг барилга ашиглалтад хүлээн авах гэрчилгээ авахаас өмнө барилгын компани худалдан авч суурилуулна.

27.4 Орон сууцны барилгын ерөнхий арилжааны тоолуурын төхөөрөмжийг ашиглалтад оруулсны дараа дулаан түгээх байгууллага нь баланстaa үнэ төлбөргүй бүртгэнэ.

27.5 Дулаан дамжуулах, түгээх байгууллага нь тоолуургүй, талбай ба эзлэхүүний нэгжээр төлбөр тооцоо хийдэг хэрэглэгчдэд тоолуур, эсхүл дулааны зардал хуваарилах төхөөрөмж суурилуулах арга хэмжээг зохион байгуулна.

27.6 Шаардлагатай хөрөнгийн эх үүсгүүрийг бүрдүүлэх арга хэмжээг энэ хуулийн 45.1-д заасан зохицуулалтын хүрээнд шийдвэрлэх арга хэмжээ авч ажиллана.

27.7 Гэрээнд өөрөөр заагаагүй бол дулаан дамжуулах эсхүл түгээх байгууллага нь өөрийн эзэмшилийн сүлжээндээ зураг төслийн дагуу тоолуурын системийг шаардлагатай туслах хэрэгслийн хамт өөрийн зардлаар сууринуулна.

27.8 Гэрээнд өөрөөр заагаагүй бол хэрэглэгчийн одоо байгаа тоолуурын систем нь техникийн шаардлагыг хангахгүй байгаа бол дулаан дамжуулах, түгээх байгууллага өөрийн зардлаар хэрэглэгчийн тоолуурыг солино.

27.9 Хэрэглэгчтэй зөвшлилцсөний үндсэн дээр төлбөр тооцооны тоолуурын зардлыг хэрэглэгч хариуцаж болно.

27.10 Хэрэв хэрэглэгч дулааны тоноглолынхoo хүчин чадлыг өөрчлөхийг хүсвэл дулаан түгээх байгууллага нь дулааны тоолуур, тоног төхөөрөмжүүдийг солих болон дахин тохируулах ажлыг хийх бөгөөд зардлыг хэрэглэгч хариуцна.

27.11 Дулаан дамжуулах, түгээх байгууллага нь сүлжээний оролт, гаралт дээрх дулааныг хэмжиж, тоолуурын мэдээллийг цуглувалж, боловсруулах үүрэгтэй.

27.12 Дулааны тоолуурт тавигдах шаардлага, тоолуурын мэдээллийг автоматаар бүртгэх үйл явцыг энэ хууль болон дулааны тоолуурын журмаар тогтооно.

28 дүгээр зүйл. Тоолуурын систем

28.1 Дулаан хангамжийн системд ухаалаг тоолуурын нэгдсэн системийг үе шаттайгаар нэвтрүүлж, хэрэглэгчийн хэрэглээний мэдээллийг цахим хэлбэрээр цуглувалах, дамжуулах, боловсруулах, хянах боломжийг бүрдүүлнэ.

28.2 Ухаалаг тоолуурын систем нь дараах шаардлагыг хангасан байна:

28.2.1 хэрэглэгчийн хэрэглээний мэдээллийг цаг хугацааны нарийвчлалтайгаар бүртгэх;

28.2.2 мэдээллийг алсаас унших, дамжуулах боломжтой байх;

28.2.3 эрчим хүчний үр ашиг, балансын дүн шинжилгээ хийх боломжтой байх.

28.3 Ухаалаг тоолуурын систем сууринуулах, ашиглах, засвар үйлчилгээ хийхтэй холбоотой стандарт, техникийн шаардлагыг Эрчим хүчний яам батална.

28.4 Төрөөс ухаалаг тоолуурын системийг нэвтрүүлэхэд шаардлагатай хөрөнгө оруулалт, дэд бүтцийн дэмжлэгийг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

29 дугаар зүйл. Хууль бус хэрэглээ

29.1 Дараах тохиолдолд дулааны эрчим хүчийг хууль бусаар хэрэглэсэн гэж үзнэ:

29.1.1 тоолуурыг гэмтээх, заалтыг өөрчлөх, хэмжүүрийн систем болон хаалт тэдгээрийн эд анги, битүүмжлэлийг алдагдуулах зэргээр зарцуулсан бодит дулааны хэмжээг нуун дарагдуулсан эсхүл бууруулсан;

29.1.2 дулаан дамжуулах, түгээх байгууллагын зөвшөөрөлгүйгээр холбогдсон, хэмжигдээгүй хэрэглээ;

29.1.3 хүчин төгөлдөр гэрээ хийгээгүй хэрэглээ.

29.2 Дулаан түгээх байгууллага нь хууль бус хэрэглээний төлбөрийг 3 дахин

нэмэгдүүлэн шаардах эрхтэй.

НАЙМДУГААР БҮЛЭГ. ҮНЭ, ТАРИФ

30 дүгээр зүйл. Дулааны тариф тогтоох эрх

30.1 Төвлөрсөн дулаан хангамжийн системд дулаан үйлдвэрлэх, дамжуулах, түгээх болон хангах тариф, хэрэглэгчдэд дулааны эрчим хүч борлуулах тарифыг Зохицуулах хороо батална.

30.2 Хэсэгчилсэн дулаан хангамжийн системийн нийт хэрэглэгчийн 50-иас дээш хувь нь тарифын зохицуулалттай болох талаар Зохицуулах хороонд хүсэлт гаргасан бол Зохицуулах хороо тарифыг батална.

31 дугаар зүйл. Тариф тогтоох механизм

31.1 Зохицуулах хороо энэ хуулиар олгогдсон эрх хэмжээнийхээ хүрээнд тариф тогтоохдоо дараах механизмыг ашиглана:

- 31.1.1 өртгийн аргад үндэслэсэн тарифын механизм;
- 31.1.2 урамшуулалт тарифын механизм;
- 31.1.3 тарифын индексжүүлэлтийн механизм;
- 31.1.4 концессын гэрээгээр тохирсон үнэ.

32 дугаар зүйл. Дулааны тариф тогтоох зарчим

32.1 Дулааны тариф нь зүй ёсны монопол аж ахуйн нэгжийг үр ашигтай ажиллуулах, үйл ажиллагааны болон хөрөнгө оруулалтын зардлыг нөхөх, зохистой тувшиний ашиг олох боломжийг хангахуйц байна.

32.2 Дулааны тариф буюу дулаан хангамжийн үйлчилгээний төлбөрийн хэмжээг тогтоохдоо дараах зарчмыг баримтална:

- 32.2.1 дулаан үйлдвэрлэх, дамжуулах, түгээх болон хангахтай холбоотой үйл ажиллагааны бодит өртөг зардлыг нөхөх;
- 32.2.2 үйл ажиллагааны болон техник, технологийн засвар үйлчилгээ, сайжруулалт, шинэчлэл, өргөтгөлд шаардлагатай хөрөнгө оруулалт хийх;
- 32.2.3 байгаль орчныг хамгаалах хууль, тогтоомжийн шаардлагыг хангах;
- 32.2.4 чанар, аюулгүй, найдвартай байдлын шаардлагыг хангах;
- 32.2.5 хөрөнгө оруулалтыг нөхөхүйц байх;
- 32.2.6 зохистой ашгийн түвшинг хангасан байх.

33 дүгээр зүйл. Өртгийн аргад үндэслэсэн тарифын механизм

33.1 Өртгийн аргад үндэслэсэн тарифын зохицуулалтын механизм буюу эдийн засгийн үндэслэлтэй зардал, зохистой ашгийн түвшинд үндэслэн дулаан хангамжийн байгууллагуудын тарифыг Зохицуулах хороо жил бүр батална.

33.2 Үйл ажиллагааны болон хөрөнгө оруулалтын зардлыг тарифт тооцоходоо Зохицуулах хороо дараах арга хэмжээг авна:

- 33.2.1 энэ хуулийн 38.1 заалтад заасан тарифын саналыг хянан шалгах

журамд тодорхойлсон зардлын нэр төрөл, ангилал бүрээр зардлын бодит хэрэгцээ, эдийн засгийн үндэслэлийг тодорхойлох;

33.2.2 хүний нөөц, түүнтэй холбогдох зардлыг салбарын хэмжээнд мөрдөгдөх жишиг норм эсхүл техник, технологийн стандартад нийцүүлэн хянах;

33.2.3 зардлыг хянаж, тогтоохдоо холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, норм, стандартыг үндэслэл болгох;

33.2.4 түлш, түүхий эд материал, тоног төхөөрөмжийн зардлыг хянаж, тогтоохдоо гадаад валютын ханш, макро эдийн засгийн үзүүлэлтийн өөрчлөлтийг үндэслэлтэйгээр тооцож тусгах;

33.2.5 үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг тооцохдоо элэгдэл байгуулах шулнуун шугамын аргыг хэрэглэх;

33.2.6 эрх бүхий байгууллагын баталсан хөрөнгө оруулалтын төслийн зардал, түүнийг эргэн төлөгдөх нөхцөлийг хангах;

33.2.7 урт ба богино хугацаат зээлийн хүүгийн зардлыг гэрээнд үндэслэн тусгах;

33.2.8 салбарын хүний нөөцийн бодлого, ажил олгогч, үйлдвэрчний эвлэл хооронд байгуулсан хамтын хэлэлцээртэй уялдаатайгаар ажиллагсдын нийгмийн зардлыг тооцож тусгах.

33.3 Зохистой ашгийн түвшинг хөрөнгө оруулалтын өгөөжийн хувьд үндэслэн дараах байдлаар тооцно:

33.3.1 хөрөнгө оруулалтын өгөөжийн хувийг капиталын жигнэсэн дундаж өртгийн аргаар тооцох;

33.3.2 тухайн жилд мөрдөгдөх капиталын жигнэсэн дундаж өртгийн утга (хувь)-ыг Зохицуулах хорооны дэргэдэх салбарын төлөөлөл, эдийн засгийн салбарын эрдэмтэн судлаачид оролцсон зөвлөлөөр жил бүр хэлэлцүүлж, өмнөх оны 12 дугаар сард багтаан батлуулах.

33.4 Өртгийн аргад үндэслэсэн тарифыг жил бүр тогтооно.

34 дугаар зүйл. Урамшуулалт тарифын механизм

34.1 Зохицуулалттай үйлчилгээний чанар, найдвартай байдал, техник эдийн засгийн үзүүлэлт, үр дүнг сайжруулах нөхцөлд үндэслэсэн урамшуулалт тарифын механизмыг тариф тогтооход ашиглаж болно.

34.2 Энэ хуулийн 34.1-д заасан тариф тогтоох нөхцөлд урамшуулалт тарифын механизmd хамрагдах нөхцөл, зорилтот үзүүлэлтийг тогтоож, тарифыг 5 хүртэл жилээр тогтооно.

34.3 Энэ хуулийн 34.1-д заасан тарифын хэрэгжилтийг Эрчим хүчиний зохицуулах хороо жил бүр дүгнэж, урамшуулалт тарифын зохицуулалтын зорилтын үзүүлэлтийг 2 жил дараалан хангаагүй тохиолдолд тарифыг цуцлах эрхтэй.

35 дугаар зүйл. Тарифын индексжүүлэлтийн механизм

35.1 Тарифын индексжүүлэлтийн механизмыг салбарын эдийн засагт дараах хүчин зүйлсийн нөлөөллөөр өртөг зардал нэмэгдэх нөхцөл бүрдсэн үед

хэрэгжүүлнэ:

35.1.1 дулааны эрчим хүч үйлдвэрлэх зориулалтаар нийлүүлж буй нүурс болон бусад түлш, эх үүсгүүрийн үнэнд өөрчлөлт орсон;

35.1.2 инфляцын өсөлт ба бууралт;

35.1.3 гадаад валютын ханшийн өсөлт ба бууралт.

35.2 Дээрх үзүүлэлтүүд бүгд эсхүл аль нэг нь 5 хувиас дээш өөрчлөлттэй гарвал тухайн хүчин зүйлд харгалзах зардлын өөрчлөлтийг тооцож, дулааны тарифыг индексжүүлнэ.

35.3 Тарифын индексжүүлэлтийг Монгол улсын нийгэм, эдийн засгийн хөгжлийн үзүүлэлтүүдээс хамааруулан жилд нэг ба түүнээс дээш удаа хэрэгжүүлж болно.

36 дугаар зүйл. Төр, хувийн хэвшлийн түншлэл (концесс)-ийн гэрээгээр тохирсон үнэ

36.1 Төр хувийн хэвшлийн түншлэл (концесс)-ийн гэрээний төслийг хэлэлцэх үед гэрээний үнийг дулаан хангамжийн үйлчилгээ үзүүлэхэд шаардагдах бодит зардал, хөрөнгийн өгөөжийн өртгөөс доогуур тогтоохыг хориглоно.

36.2 Төр хувийн хэвшлийн түншлэл (концесс)-ийн гэрээний үнийг тогтоохдоо тарифын саналыг хянан шалгах журмын дагуу явуулна.

36.3 Үнийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн концесс эзэмшигч болон эрх бүхий байгууллагын санаачилгаар тогтооно.

36.4 Үнийн үйлчлэх хугацааг төр хувийн хэвшлийн түншлэл (концесс)-ийн гэрээг хэрэгжүүлэх хугацаанаас хэтрэхгүй хугацаагаар тогтооно.

37 дугаар зүйл. Хэрэглэгчдэд дулааны эрчим хүч борлуулах тариф

37.1 Хэрэглэгчдэд дулааны эрчим хүч борлуулах тарифыг тогтоохдоо дараах зарчмыг баримтална:

37.1.1 хэрэглэгчдэд дулааны эрчим хүчийг тээвэрлэн хүргэх бодит өртөгт үндэслэсэн, хэрэглэгчийн ангилал бүрээр ялгаатай байх;

37.1.2 дулааны эрчим хүчийг хэмнэлттэй хэрэглэхэд хөшүүрэг болохуйц байх;

37.1.3 дулааны оргил ачааллын болон хэвийн горимын үед мөрдөх тариф ялгаатай байх;

37.1.4 дулааны эрчим хүчний тарифыг дулаан хангамжийн бүсээр тогтоох.

38 дүгээр зүйл. Тариф батлуулах хүсэлт гаргах

38.1 Энэ хуульд нийцүүлэн дулаан хангамжийн байгууллагын тарифын саналыг хянах, шалгах журмыг Зохицуулах хороо батална.

38.2 Дулаан хангамжийн байгууллага нь тариф батлуулах хүсэлт, тарифын саналыг эрх бүхий байгууллагад цахим хэлбэрээр ирүүлнэ.

38.3 Тарифын санал, тариф батлуулах хүсэлтийг эрх бүхий байгууллага ирүүлсэн өдрөөс хойш 90 хоногийн дотор хянаж, батална.

39 дугаар зүйл. Тариф батлуулахад бүрдүүлэх материал

39.1 Тариф батлуулах хүсэлтэд дараах тооцооны бичиг баримтыг хавсаргаж
Page 29 of 46

иrudнэ:

- 39.1.1 тарифын төсөл;
- 39.1.2 эрх бүхий байгууллагаас баталсан маягтын дагуу дагалдах материалыг хавсаргасан тарифын тооцооны төсөл;
- 39.1.3 хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн төсөл;
- 39.1.4 хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн хүрээнд хийгдэх засвар, сайжруулалт, шинэчлэл, өргөтгөлийн зураг төсөв;
- 39.1.5 салбарын норм, дүрэм, стандартад үндэслэсэн боловсон хучний тоо хэмжээ, цалингийн зардал, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлын тооцоо;
- 39.1.6 дулаан үйлдвэрлэхэд ашиглах түлш, түүхий эд, материалын зардлын тооцоо;
- 39.1.7 дулааны эрчим хүчийг сүлжээгээр дамжуулахад гарах техникийн алдагдлын тооцоо;
- 39.1.8 техник ашиглалтын дүрэм, холбогдох стандартын дагуу урсгал засварын ажилд хуваарилсан зардлын тооцоо;
- 39.1.9 Зохицуулах хорооноос баталсан журмын дагуу хийсэн бусад үйл ажиллагааны зардлын зүйлчилсэн тооцоо;
- 39.1.10 зохистой түвшин бүхий ашгийн тооцоо.

39.2 Тариф батлуулах хүсэлтэд дараах тайлан, бусад бичиг баримтыг хавсаргаж ируднэ:

- 39.2.1 өмнөх хуанлийн хоёр жилийн санхүүгийн тайлан;
- 39.2.2 үйл ажиллагааны тайлангууд: санхүү, эдийн засгийн үйл ажиллагааны; хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны тухай; үндсэн хөрөнгийн төлөв байдал; статистикийн эрх бүхий байгууллагаас баталсан маягтын дагуу хуанлийн өмнөх хоёр жилийн хөдөлмөрийн хөлсний бүтэц, хуваарилалтын тухай;
- 39.2.3 өмнөх хуанлийн жилийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны тайлан, тендерийн комиссын шийдвэрийн хуулбар;
- 39.2.4 өмнө батлагдсан хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн хүрээнд ашиглалтад оруулсан үндсэн хөрөнгө, түүнд ногдох үндсэн хөрөнгийн элэгдлийн шимтгэлийн тооцоог урт хугацаанд, жилээр нь ангилсан тайлан;
- 39.2.5 урт ба богино хугацаат зээлийн гэрээ, санхүүжүүлэх болон зээлийн эргэн төлөгдөх хуваарийг нотолсон баримт бичиг;
- 39.2.6 дулаан хангамжийн байгууллагын үндсэн тоноглолын хүчин чадал, хүчин чадал ашиглалтын талаар салбарын мэдээллийн нэгдсэн сангаас гаргасан мэдээлэл;
- 39.2.7 бусад.

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ. ХЭРЭГЛЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ, ГЭРЭЭ

40 дүгээр зүйл. Хэрэглэгчийн эрх, үүрэг

40.1 Хэрэглэгч энэ хуулийн Тав дугаар бүлэгт зааснаас гадна 411-р зүйлд заасан дулааны эрчим хүчээр хангах гэрээгээр эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

41 дугаар зүйл. Дулаан хангамжийн байгууллага болон хэрэглэгч хооронд байгуулах гэрээ

41.1 Дулаан хангамжийн байгууллага болон хэрэглэгч хоорондын харилцаа дараах гэрээгээр зохицуулагдана:

41.1.1 дулаан дамжуулах, түгээх байгууллага нь хэрэглэгчтэй дулааны эрчим хүчээр хангах гэрээ байгуулна;

41.1.2 үйлдвэрлэх байгууламжид шууд холбогдсон хэрэглэгчидтэй үйлдвэрлэгч нь дулааны эрчим хүчээр хангах гэрээ байгуулна.

41.2 Төвлөрсөн дулаан хангамжийн системийн хүрээнд дулаан хангамжийн байгууллага болон хэрэглэгчийн хоорондын харилцааг зохицуулсан гэрээ нь загвар гэрээний үндсэн дээр хийгдэнэ.

41.3 Энэ хуулийн 41.2-т заасан дулааны эрчим хүчээр хангах загвар гэрээг Зохицуулах хороо батална.

41.4 Дулааны эрчим хүчээр хангах загвар гэрээ аж ахуйн нэгж байгууллага болон ахуйн хэрэглээний хувьд ялгаатай байж болно.

42 дугаар зүйл. Дулааны эрчим хүчээр хангах гэрээ

42.1 Хэрэглэгчид дулаан дамжуулах, түгээх байгууллагаас дулааны эрчим хүчээр хангах гэрээний үндсэн дээр дулаан, сүлжээний усыг худалдан авна.

42.2 Дулааны эх үүсгүүрт шууд холбогдсон хэрэглэгч нь үйлдвэрлэгчээс дулааны эрчим хүчээр хангах гэрээний үндсэн дээр уур ба сүлжээний ус, дулааны эрчим хүч худалдан авна.

42.3 Гэрээний дагуу дулаан хангамжийн байгууллага нь хэрэглэгчид гэрээнд заасан чанар, хэмжээгээр дулаан нийлүүлэх үүрэгтэй бөгөөд хэрэглэгч нь хэрэглэсэн дулааны төлбөрийг төлөх, гэрээнд заасан дулааны хэрэглээний горимыг мөрдөх, дулаан хангамжийн тоног төхөөрөмж, сүлжээ болон тоолуурыг зохих түвшинд ашиглах, аюулгүй ажиллагааг хангах үүрэгтэй.

42.4 Дулаан дамжуулах, түгээх сүлжээнд холбогдоход шаардлагатай хэрэглэгчийн тоноглол, тоолуурын суурилуулалт хийгдсэн тохиолдолд дулаан хангамжийн байгууллага дулааны эрчим хүчээр хангах гэрээг хэрэглэгчтэй байгуулна.

42.5 Дулааны эрчим хүчээр хангах гэрээнд дараах зүйлсийг заавал тусгана:

42.5.1 талуудын эрх, үүрэг, хариуцлага;

42.5.2 нийлүүлэх дулааны чанар, тоо хэмжээ;

42.5.3 дулаан нийлүүлэхийг хязгаарлах, зогсох нөхцөл;

42.5.4 дулааны хэрэглээний горим;

- 42.5.5 үнэ, тариф;
 - 42.5.6 гадна агаарын температурт харгалзах температурын график;
 - 42.5.7 сүлжээний өмчлөл, эзэмшил, хариуцлагын зааг;
 - 42.5.8 дэд хэрэглэгчдийн талаарх мэдээлэл (хэрэв байгаа бол);
 - 42.5.9 гэрээг дуусгавар болгох нөхцөл;
 - 42.5.10 гэрээг хэрхэн дүгнэх талаарх зохицуулалт;
 - 42.5.11 хэрэглэгчийн хэрэглэсэн дулааныг хэмжих, тооцох арга болон арилжааны хэмжих хэрэгсэлд тавих шаардлага.
- 42.6 Энэ хуулийн 41.2-т зааснаас бусад тохиолдолд талууд дулааны эрчим хүчээр хангах гэрээний бусад нөхцөлийг харилцан тохиролцож гэрээнд тусгаж болно.
- 42.7 Нийтийн орон сууцанд дулаан хангамжийн үйлчилгээ үзүүлэх гэрээ нь тус барилгын оршин суугчдын болон орон сууцны бус талбайг оролцуулан нийт талбайн халаалтын хэрэгцээг хангахад шаардагдах дулааныг нийлүүлэхээр хийгдэнэ. Энэхүү гэрээ нь тухайн барилгыг дулааны сүлжээнд анх холбогдсон өдрөөс эхлэн бүх оршин суугчид болон орон сууцны бус талбайн эздэд хүчин төгөлдөр мөрдөгдөнө.
- 42.8 Нийтийн орон сууцны оршин суугч буюу орон сууцны бус талбайн эзэмшигч нь тухайн барилгын төвлөрсөн эсхүл хэсэгчилсэн дулаан хангамжийн системд холбогдсон тохиолдолд дулаан хангамжийн гэрээнээс нэг талын санаачилгаар татгалзах эрхгүй.
- 42.9 Аж ахуй нэгж, байгууллагатай байгуулсан дулааны эрчим хүчээр хангах гэрээг жил бүр дүгнэж, гэрээ дүгнэсэн акт үйлдэж баталгаажуулна.
- 42.10 Ахуйн хэрэглэгчтэй байгуулсан дулааны эрчим хүчээр хангах гэрээг дүгнэх хугацаа нэгээс дээш жил байж болох ба энэ талаар гэрээнд тусгана.

АРАВДУГААР БҮЛЭГ. МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН СИСТЕМ

- 43 дүгээр зүйл. Салбарын мэдээллийн тогтолцоо
- 43.1 Эрчим хүчний салбар нь техникийн болон үйл ажиллагааны үзүүлэлтийг төрөлжүүлэн бүртгэдэг мэдээллийн сангаас бүрдэх мэдээллийн нэгдсэн системтэй байна.
- 43.2 Салбарын мэдээллийг дараах байдлаар төрөлжүүлэн мэдээллийн санд бүртгэнэ:
- 43.2.1 эрчим хүчний байгууламж байгууламж, үндсэн тоног төхөөрөмжийн мэдээлэл;
 - 43.2.2 дулаан хангамжийн системийн бүртгэл, холбогдох мэдээлэл
 - 43.2.3 эрчим хүчний үйлдвэрлэл, хэрэглээний мэдээлэл;
 - 43.2.4 салбарт үйл ажиллагаа явуулж буй байгууллагуудын техник, эдийн засгийн үндсэн үзүүлэлтийн мэдээлэл;
 - 43.2.5 санхүүгийн мэдээлэл;

- 43.2.6 их засвар, техник зохион байгуулалтын арга хэмжээ, хөрөнгө оруулалт, бусад засвар шинэчлэлтийн мэдээлэл;
- 43.2.7 худалдан авах ажиллагааны мэдээлэл;
- 43.2.8 ёвлийн бэлтгэл хангах ажлын явцын мэдээлэл;
- 43.2.9 технологийн горим ажиллагааны мэдээлэл;
- 43.2.10 технологийн зөрчлийн мэдээлэл;
- 43.2.11 хүний нөөцийн статистик мэдээлэл;
- 43.2.12 шаардлагатай гэж үзсэн бусад мэдээлэл.

43.3 Мэдээллийн сан үүсгэх ажлын хүрээнд хувь хүний болон байгууллагын бизнесийн нууцтай холбоотой мэдээллийг шаардахыг хориглоно.

43.4 Мэдээллийн санд мэдээлэл оруулах, мэдээлэлд нэвтрэх, ашиглах, боловсруулалт хийх, судалгаа, дүн шинжилгээний тайлан гаргах үйл ажиллагааг хэрэгжүүлэхийн тулд мэдээллийн нэгдсэн системийг цахимаар бий болгож, хөгжүүлж, ашиглана.

43.5 Салбарын хэмжээний бодлого, төлөвлөлт, хэрэгжилт, тайлан гаргалт, хяналт-шинжилгээ, үнэлгээг үр дүнтэй хэрэгжүүлэхэд салбарын мэдээллийн нэгдсэн системийг үр дүнтэй ашиглах, түүнд чиглэсэн хөгжүүлэлтүүдийг хийнэ.

43.6 Салбарын мэдээллийн нэгдсэн систем, мэдээллийн сангийн удирдлага, зохион байгуулалтыг хариуцах байгууллагыг төрийн захиргааны төв байгууллага тодорхойлж, холбогдох зардлыг санхүүжүүлнэ.

43.7 Салбарын мэдээллийн нэгдсэн сангийн удирдлага, зохион байгуулалтын журмыг Төрийн захиргааны төв байгууллага батална.

43.8 Энэ хуулийн 43.7-д заасан журамд дараах асуудлуудыг тусгана:

- 43.8.1 салбарын мэдээллийн нэгдсэн системийн бүтэц, зохион байгуулалт;
- 43.8.2 төрөлжсөн мэдээллийн санд хадгалагдах өгөгдлийн нэр төрөл;
- 43.8.3 өгөгдөл, мэдээлэлд тавигдах шаардлага;
- 43.8.4 өгөгдөл, мэдээлэл цуглуулах давтамж;
- 43.8.5 өгөгдөл, мэдээллийг төрөлжсөн мэдээллийн санд оруулах эрх бүхий этгээд, түүний үүрэг, хариуцлага;
- 43.8.6 төрөлжсөн мэдээллийн сангийн хадгалалт, хамгаалалт;
- 43.8.7 мэдээллийн нэгдсэн системийн ашиглалт, хандах эрхийн зохицуулалт;
- 43.8.8 мэдээллийн нэгдсэн системийн хөгжүүлэлт, шинэчлэлт;
- 43.8.9 мэдээллийн үйлчилгээ үзүүлэх.

43.9 Энэ хуулийн 43.6-д заасан байгууллага нь мэдээллийн нэгдсэн систем ашиглах заавар боловсруулж, салбарын байгууллагуудыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллана.

АРВАН НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ТӨСӨЛ ХӨТӨЛБӨР, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

44 дугаар зүйл. Төсөл, хөтөлбөр

44.1 Дулаан хангамжийн салбарын төсөл, хөтөлбөр (цаашид “төсөл, хөтөлбөр” гэх)-т одоо байгаа болон шинээр бий болох төвлөрсөн болон хэсэгчилсэн дулаан хангамжийн системд дулааны барилга байгууламж барих, өөрчлөх, шинэчлэх, тоног төхөөрөмж суурилуулах, технологи нэвтрүүлэх ажил, үйлчилгээ хамаарна.

44.2 Төсөл, хөтөлбөр нь дулаан хангамжийн хөгжлийн төлөвлөгөө (схем)-тэй нийцсэн байхаас гадна дараах шаардлагыг хангасан байна:

44.2.1 дулаан хангамжийн хөгжлийн төлөвлөгөө (схем)-д тодорхойлсон дулаан хангамжийн бүс, байршилд байх;

44.2.2 тухайн дулаан хангамжийн системд тохирсон түлш ашиглах;

44.2.3 эрчим хүчний хэмнэлттэй техник, технологи, тоног төхөөрөмж, эсхүл сэргээгдэх эрчим хүчний эх үүсгүүр эсхүл бусад хүлэмжийн хийн ялгарал багатай эх үүсгүүрийг ашиглах замаар дулаан үйлдвэрлэлт, дамжуулалт, түгээлт, борлуулалтын явц дахь дулааны алдагдлыг бууруулах, үр ашгийг дээшлүүлэхэд чиглэсэн байх.

44.3 Төсөл, хөтөлбөрийн зураг төсөл, төсөв болон өмнөх шатны баримт бичгүүд нь энэ хуулийн 44.2-т заасан шаардлагыг хангасан байна.

44.4 Төсөл, хөтөлбөрийн хэрэгжүүлэгчийг (гүйцэтгэгч, концесс эзэмшигч, хувийн хөрөнгө оруулагч) сонгохдоо дараах шалгуур үзүүлэлтийг хамгийн сайн хангасан этгээдийг сонгоно:

44.4.1 дулаан хангамжийн найдвартай байдал;

44.4.2 дулаан хангамжийн аюулгүй байдал;

44.4.3 дулааны барилга байгууламжийг засварлах, солихгүйгээр ашиглах боломжит хугацаа;

44.4.4 агаарт ялгаруулах хорт бодисын түвшин;

44.4.5 эрчим хүчний үр ашиг, хэмнэлтийн үзүүлэлт, дулаан алдагдлын түвшин;

44.4.6 хуульд заасан бусад үзүүлэлт.

45 дугаар зүйл. Хөрөнгө оруулалтыг дэмжих механизм

45.1 Төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгө оруулалтыг дэмжихэд дараах механизмыг ашиглана:

45.1.1 улс, орон нутгийн төсвийн санхүүжилт;

45.1.2 татварын хөнгөлөлт;

45.1.3 улс, орон нутгийн төсвөөс тодорхой үйл ажиллагааны чиглэлээр татаас олгох;

45.1.4 төр хувийн хэвшлийн түншлэлийн механизм;

45.1.5 хөрөнгө оруулалтыг дулаан хангамжийн байгууллагын тарифт тусгах замаар нөхөх;

- 45.1.6 олон улсын буцалтгүй тусlamж, хөнгөлөлттэй зээлээр санхүүжүүлэх;
- 45.1.7 сэргээгдэх эрчим хүч ашиглах, эрчим хүч хэмнэх, үр ашгийг дээшлүүлэхэд чиглэсэн төсөл, хөтөлбөрт үзүүлэх дэмжлэг, ногоон зээл;
- 45.1.8 энэ хуулийн хүрээнд хувийн хөрөнгө оруулалтыг дэмжих.

46 дугаар зүйл. Хөрөнгө оруулалтыг тарифаар нөхөх механизм

46.1 Зохицуулах хороо нь үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг тарифт бүрэн тусгах замаар дулаан хангамжийн байгууллагын өмчлөлийн эх үүсгүүр, дамжуулах, түгээх сүлжээнд хийгдэх засвар, шинэчлэлт, өргөтгөлийг техникийн шаардлага, норм стандартад нийцүүлэн хэрэгжүүлэх зохицуулалтыг хийх үүрэгтэй.

46.2 Дулаан хангамжийн байгууллага нь ирэх 3-5 жилд хийгдэх хөрөнгө оруулалтын төлөвлөгөөгээг эрх бүхий байгууллагаар батлуулан Зохицуулах хороонд жил бүрийн 11 дүгээр сард багтаан ирүүлэх үүрэгтэй.

46.3 Энэ хуулийн 46.2-т заасан төлөвлөгөө нь дараах бүрдлийн шаардлагыг хангасан байна:

- 46.3.1 хөрөнгө оруулалтын хэмжээ;
- 46.3.2 хөрөнгө оруулалтын эх үүсвэр;
- 46.3.3 төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх хэлбэр;
- 46.3.4 төсөл хөтөлбөрийн техник эдийн засгийн үр ашгийн үнэлгээ;
- 46.3.5 төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх хуваарь;
- 46.3.6 хөрөнгө оруулалтыг зээлээр санхүүжүүлэх бол зээлийн нөхцөл, эргэн төлөгдөх хуваарь.

46.4 Зохицуулах хороо нь хөрөнгө оруулалтын төсөл, хөтөлбөрийн үндэслэл, үр ашигтай байдлыг үнэлэх, үр ашиггүй төслийн хөрөнгө оруулалтыг тарифт тусгахаас татгалзах эрхтэй.

46.5 Зохицуулах хороо дулаан хангамжийн байгууллагын тарифыг тогтоохдоо хөрөнгө оруулалтыг эргэн төлөх нөхцөлийг заавал хангасан байх үүрэгтэй.

47 дугаар зүйл. Улс, орон нутгийн төсвөөс татаас олгох механизм

47.1 Дулаан хангамжийн салбарыг хөгжүүлэх эдийн засгийн хөшүүрэг болгож дулаан хангамжийн системийг барих, шинэчлэх, сайжруулахад олгох татаасыг улс, орон нутгийн төсөвт тусгана.

47.2 Дулаан хангамжийн системийг барих, шинэчлэх, сайжруулахад дараах чиглэлээр татаас олгоно:

- 47.2.1 техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл, төсөв боловсруулах, техникийн болон зохиогчийн хяналт хийх зэргээр төсөл, хөтөлбөрт техникийн дэмжлэг үзүүлэх;
- 47.2.2 дулаан хангамжийн системийн дулааны барилга байгууламж барих, шинэчлэх, сайжруулах барилга угсралтын ажил, эсхүл тоног төхөөрөмж суурилалт, технологи нэвтрүүлэлтийн үйлчилгээнд шаардлагатай хөрөнгө оруулалтыг хийх.

47.3 Салбарын санхүү, эдийн засгийн чадавх, бие даасан байдлыг дээшлүүлэх зорилгоор үнэ, тарифын зөв зохистой бодлогын шинэчлэлт хийх замаар дулаан хангамжийн байгууллагад олгох татаасыг үе шаттайгаар халах бодлого баримтална.

48 дүгээр зүйл. Сэргээгдэх эрчим хүч ашиглах, эрчим хүч хэмнэх, үр ашгийг дээшлүүлэхэд чиглэсэн төсөл, хөтөлбөр

48.1 Сэргээгдэх эрчим хүч ашиглах, эрчим хүч хэмнэх, үр ашгийг дээшлүүлэхэд чиглэсэн төсөл, хөтөлбөрт дараах чиглэлээр бодлогын дэмжлэг үзүүлнэ:

48.1.1 сэргээгдэх эрчим хүчний эх үүсгүүр ашиглан дулаан үйлдвэрлэхийг дэмжих;

48.1.2 сэргээгдэх эрчим хүчний эх үүсгүүр барих үйл явцыг тусгай нөхцөл бүхий хялбаршуулсан журмаар зохицуулах хууль эрх зүйн орчныг бүрдүүлж, дэмжлэг үзүүлэх;

48.1.3 орон нутгийн дулаан хангамжийн хөгжлийн төлөвлөгөө (схем)-д эрчим хүч хэмнэх, үр ашгийг дээшлүүлэх, сэргээгдэх эрчим хүч нэвтрүүлэх арга хэмжээг эдийн засаг болон техникийн үндэслэлд тулгуурлан тусгах;

48.1.4 шаардлагатай дэд бүтэц бий болгох, судалгаа хөгжүүлэлт хийх, мэргэжлийн хүний нөөц бэлтгэх, эрчим хүч хэмнэх, үр ашгийг дээшлүүлэх, сэргээгдэх эрчим хүч ашиглах сайн туршлагыг нэвтрүүлэх арга хэмжээг хөгжлийн бодлого, төлөвлөлтөд тусгаж, улс, орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх.

48.2 Сэргээгдэх эрчим хүч ашиглах, эрчим хүч хэмнэх, үр ашгийг дээшлүүлэхэд чиглэсэн төсөл, хөтөлбөрийг Монгол Улсад болон олон улсад хэрэгжүүлж буй ногоон зээлээр санхүүжүүлэх механизмыг бий болгох бодлогыг салбарын хөгжлийн бодлого, төлөвлөлтөд тусгаж, хэрэгжилтийг хангах үүргийг төрийн захиргааны төв байгууллага хүлээнэ.

АРВАН ХОЁРДУГААР БҮЛЭГ. СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧ, ДУЛААНЫ ҮР АШИГ

49 дугаар зүйл. Сэргээгдэх эрчим хүчийг хөгжүүлэх бодлого

49.1 Сэргээгдэх эрчим хүчийг хөгжүүлэх, дулааны үр ашгийг сайжруулах бодлогын зорилтыг төрийн захиргааны төв байгууллага салбарын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусган батална.

49.2 Сэргээгдэх эрчим хүчийг дулаан хангамжид ашиглах дараах бодлогыг салбарын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тодорхойлж тусгана:

49.2.1 тухайн бүс, орон нутгийн онцлог, эрчим хүчний нөөцөд тулгуурлан дулаан хангамжид сэргээгдэх эрчим хүчний эх үүсгүүрийг ашиглах зорилтыг тодорхойлох;

49.2.2 сэргээгдэх эрчим хүчийг дулаан хангамжид ашиглах үр ашигтай тэргүүлэх техник, технологийг тусгах.

49.3 Төрөөс дулаан хангамжийн системд сэргээгдэх эрчим хүч ашиглах технологи, түүний дотор дулааны насос ашиглалтыг дэмжинэ.

49.4 Дулааны насосыг орон сууц, албан байгууллага, үйлдвэрлэл, нийтийн

үйлчилгээний барилга байгууламжид суурилуулсан тохиолдолд дараах хэлбэрээр дэмжлэг үзүүлж болно:

- 49.4.1 ашигласан цахилгаанд хөнгөлөлттэй тариф тогтоох;
- 49.4.2 тоног төхөөрөмж худалдан авахад зориулсан татварын хөнгөлөлт;
- 49.4.3 хувийн хэвшил, өрхийн хөрөнгө оруулалтыг хүү багатай зээл, татаасаар дэмжих.

49.5 Дулааны насос ашиглаж буй хэрэглэгчдийн цахилгааны тарифыг уур амьсгалын бүс, улирал, хэрэглээний хэлбэрт нийцүүлэн Эрчим хүчний зохицуулах хорооноос тогтооно.

49.6 Дулааны насосын суурилуулалт, ашиглалтыг орон нутгийн хөгжлийн бодлогод тусгаж, төсвийн дэмжлэг үзүүлэх боломжийг бүрдүүлнэ.

50 дугаар зүйл. Дулааны үр ашгийг сайжруулах бодлого

50.1 Дулааны үр ашгийг сайжруулах дараах бодлогыг салбарын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тодорхойлж тусгана:

- 50.1.1 дэвшилтэт техник технологийг дэмжих, хөгжүүлэх;
- 50.1.2 дулаан хадгалах, хурумтлуулах техник технологийг хөгжүүлж, нэвтрүүлэх;
- 50.1.3 дамжуулах, түгээх сүлжээний даралт, температурын алдагдлыг бууруулах дэвшилтэт техник, технологийг хөгжүүлж, нэвтрүүлэх;
- 50.1.4 дулааны эрчим хүчний хоёрдогч нөөцийг зохистой ашиглах техник, технологи (дулааны сүлжээний буцах усны дулааныг ашиглах, үйлдвэрлэлийн процесст хаягдаж буй дулааныг ашиглах гэх мэт)-г хөгжүүлж, нэвтрүүлэх;
- 50.1.5 барилгын дулаан алдагдлын бууруулах чиглэлээр барилгын дулаан алдагдлын түвшинг тодорхойлж гэрчилгээжүүлэх, гэрчилгээгүй барилгыг дулаанд холбохгүй байх.

50.2 Хотын Захиргач, аймгийн Засаг дарга нь дулааны хангамжийн системийн хөгжлийн төлөвлөгөө (схем)-ийг боловсруулж батлуулахдаа энэ хуулийн 49.1, 49.2, 50.1-т нийцүүлсэн байна.

50.3 Төвлөрсөн болон бие даасан дулаан хангамжийн системд сэргээгдэх эрчим хүчний эх үүсгүүр ашиглах, дулааны үр ашгийг сайжруулах төслийн хөрөнгө оруулалтад энэ хуулийн 48-д заасны дагуу дэмжлэг үзүүлнэ.

АРВАН ГУРАВДУГААР БҮЛЭГ. ТЕХНИК, ТЕХНОЛОГИЙН НОРМ, СТАНДАРТ, АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ШААРДЛАГА

51 дүгээр зүйл. Ашиглалтын техник, технологийн норм, стандарт

51.1 Төрийн захиргааны төв байгууллага эрчим хүчний хэмнэлт, үр ашгийг нэмэгдүүлэх эрх бүхий байгууллагатай хамтран төвлөрсөн болон хэсэгчилсэн дулаан хангамжийн системд дулаан үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, хангах үйл ажиллагаа явуулахад хэрэглэгдэж буй дулааны барилга байгууламжийн ашиглалтын болон эрчим хүчний үр ашигтай байдлын талаарх техник, технологийн норм, нормативын баримт бичгийг боловсруулж батлахаас гадна, энэ төрлийн

стандартыг боловсруулж эрх бүхий байгууллагаар батлуулна.

52 дугаар зүйл. Аюулгүй байдлын ерөнхий шаардлага

52.1 Дулааны эх үүсгүүр, сүлжээ, тоног төхөөрөмж, хэрэглэгчийн тоноглолтыг ашиглах үед авч хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ нь хүний амь нас, эрүүл мэнд болон байгаль орчны аюулгүй байдлыг хангасан байна.

52.2 Техник, технологийн норм, стандартыг дулааны эрчим хүч болон түүнийг үйлдвэрлэх, дамжуулах, түгээх болон хэрэглэхэд тус тус дагаж мөрдөнө.

52.3 Дулааны сүлжээн дэх эрчим хүчиний үзүүлэлтүүд нь тогтоосон температурын графикт нийцсэн байна

53 дугаар зүйл. Хамгаалалтын зурвас

53.1 Дулааны сүлжээ нь аюулгүй байдлыг хангах хамгаалалтын зурвастай байна. Хамгаалалтын зурвасын дотор газар эзэмших, ашиглах, өмчлөх аль ч хэлбэрээр газар олголт хийх, хашаа барих, гэр, орон сууц, барилга байгууламж барих болон сүлжээ өмчлөгч, эзэмшигчийн зөвшөөрснөөс бусад үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

53.2 Хот, тосгоны Захирагч, аймаг, сум, дүүргийн Засаг дарга сүлжээг хамгаалах дүрмийн дагуу хамгаалалтын зурвасын хэмжээг баталгаажуулна.

53.3 Хамгаалалтын зурвасын дотор тарьсан, ургасан мод, бут нь сүлжээнд гэмтэл учруулахаар буюу үзлэг, үйлчилгээ хийхэд саад болохоор бол мод, бутны өмчлөгч, эзэмшигч нь түүнийг шилжүүлэн суулгах, тайрах, огтлох үүрэгтэй.

53.4 Эрчим хүчиний хяналтын улсын байцаагч, эрчим хүчээр хангагчийн эрх бүхий ажилтан нь сүлжээнд үзлэг, үйлчилгээ хийх, хяналт хэрэгжүүлэх зорилгоор хамгаалалтын зурвасын дагуу бусдын эзэмшил, ашиглалтад байгаа газар, барилга байгууламжид нэвтрэн орох, дайран өнгөрөх, өмчлөгч, эзэмшигч нь энэ хуулийн 53.3-т заасан үүргээ биелүүлээгүй бол уг мод, бутыг шилжүүлэн суулгуулах, хэрэв боломжгүй бол тайрч огтлуулах арга хэмжээ авах эрхтэй.

53.5 Дулааны эрчим хүчийг үйлдвэрлэх, дамжуулах, түгээх технологийн нэгдсэн үйл явцад оролцож, төвлөрсөн дулаан хангамжийн системд ашиглагдаж байгаа дулаан хангамжийн байгууллагын эд хөрөнгө нь салгах боломжгүй нэгдмэл байна.

53.6 Төвлөрсөн дулаан хангамжийн системд дулааны эх үүсгүүр, сүлжээ ба (эсхүл) тэдгээрийн хэсгүүдийг худалдах, худалдан авах, түрээслэхдээ эрх бүхий байгууллагад урьдчилан мэдэгдсэнээр хэрэгжүүлнэ.

54 дүгээр зүйл. Түлшинд тавигдах чанарын шаардлага

54.1 Төвлөрсөн болон хэсэгчилсэн дулаан хангамжийн системийн дулааны эх үүсгүүрт ашиглах түлшний чанарт тавих шаардлагыг тодорхойлсон техник, технологийн норм, нормативын баримт бичгийг төр захиргааны төв байгууллага батална.

55 дугаар зүйл. Түлшний нийлүүлэлт, ашиглалттай холбоотой талуудын үүрэг, хариуцлага

55.1 Төвлөрсөн болон хэсэгчилсэн дулаан хангамжийн системийн дулааны эх үүсгүүрт түлш нийлүүлэгчийн хүлээх эрх, үүргийг түлш нийлүүлэлтийн гэрээгээр

тогтооно.

55.2 Түлш нийлүүлэгч нь түлш нийлүүлэх гэрээний нөхцөл, хуваарийн дагуу шаардлагатай хэмжээний түлшийг тасралтгүй нийлүүлэх үүрэгтэй.

55.3 Төвлөрсөн болон хэсэгчилсэн дулаан хангамжийн системд дулаан үйлдвэрлэх болон түгээх үйл ажиллагаа хамт эрхэлдэг байгууллага нь түлшний нийлүүлэлтийн хэмжээ, чанар, ашиглалтын талаар хотын Захиргагч, аймгийн Засаг даргад жил бүр тайлагнах үүрэгтэй.

55.4 Хотын Захиргагч, аймгийн Засаг дарга нь бие даасан дулаан хангамжийн системд ашиглагдаж буй түлшний төрөл, хэмжээний талаарх мэдээллийг цуглуулна.

55.5 Хотын Захиргагч, аймгийн Засаг дарга энэ хуулийн 55.3, 55.4-т заасан түлшний нийлүүлэлтийн хэмжээ, чанар, ашиглалтын талаарх мэдээллийг 43.2-т заасан мэдээллийн санд бүртгэнэ.

56 дугаар зүйл. Дулаан зөөгчийн чанарт тавигдах шаардлага

56.1 Төвлөрсөн болон хэсэгчилсэн дулааны сүлжээнд усыг дулаан зөөгчөөр ашиглах ба түүнд тавигдах чанарын шаардлагыг энэ хуулийн 51.1-т заасан баримт бичгээр тодорхойлно.

56.2 Дулаан зөөгчийн чанарын шаардлагыг дулаан хангамжийн байгууллага тогтмол хянаж байх үүрэгтэй.

56.3 Дулаан зөөгчийн чанарт хяналт, хэмжилт хийх журмыг дулаан хангамжийн байгууллага дотооддоо баталж мөрдөнө.

57 дугаар зүйл. Зураг төсөл, ашиглалтын аюулгүй байдлын шаардлага

57.1 Дулааны эх үүсгүүр, сүлжээ, хэрэглэгчийн тоноглолын техник, тоног төхөөрөмжийн зураг төсөл боловсруулах, тэдгээрийг ашиглахад энэ хууль болон энэ хуулийн 51.1-т заасан норм, стандартыг дагаж мөрдөнө.

57.2 Монгол улсад үйлдвэрлэсэн болон импортоор орж ирсэн дулаан үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, хэрэглэхэд ашиглах дулаан-механикийн тоног төхөөрөмж, материал хүний амь нас, эрүүл мэнд болон байгаль орчинд аюулгүй байлгах шаардлагыг хангасан байхаас гадна холбогдох дүрэм, журам, норм, стандартад нийцсэн байна.

57.3 Энэ хуулийн 57.2-т заасан нийцлийг хангаж байгаа эсэхийг нотолсон байх шаардлагатай ба баталгаажуулаагүй техник, тоног төхөөрөмжийг ашиглахыг хориглоно.

58 дугаар зүйл. Дулаан хангамжийн аюулгүй байдлын үзүүлэлтүүд

58.1 Эрх бүхий байгууллагын баталсан дулааны хангамжийн байгууллагууд, хэрэглэгчийн дагаж мөрдөх техникийн баримт бичгүүд нь дулааны барилга байгууламжийн найдвартай, аюулгүй ажиллагааны хамгийн бага болон төлөвлөгөөт үзүүлэлтүүдийг тооцох, батлах үйл явцыг агуулсан байна.

58.2 Найдвартай, аюулгүй байдлын хамгийн бага үзүүлэлтэд нийцээгүй дулааны барилга байгууламжийг ашиглахыг хориглоно.

58.3 Төвлөрсөн дулаан хангамжийн системд ажиллаж буй дулаан хангамжийн

байгууллага нь дулаан хангамжийн барилга байгууламж, тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааны шаардлагыг заавал хангах үүрэгтэй байна.

59 дүгээр зүйл. Халаалтын улирлын бэлэн байдлыг хангах

59.1 Төвлөрсөн дулаан хангамжийн системийн байгууллагууд нь халаалтын улирлын бэлэн байдлыг хангах хүрээнд дараах арга хэмжээг авч ажиллана.

59.1.1 дулаан хангамжийн шугам тоноглолд хийх засварын ажлын графикийг эрх бүхий байгууллагаар батлуулах;

59.1.2 засварын ажлыг төлөвлөгөөний дагуу гүйцэтгэж, ажлын гүйцэтгэлийн явц, тайланг эрх бүхий байгууллагад тухай бүр тайлагнах;

59.1.3 дулааны тоног, төхөөрөмж, шугам сүлжээг халаалтын улиралд бэлтгэх арга хэмжээг авч, шаардлагатай туршилт, хэмжилтийн ажлыг гүйцэтгэж бэлэн болгох;

59.1.4 горим ажиллагаанд нөлөөтэй хэрэглэгчдийн дулааны шугам, тоноглолд шаардлагатай засвар үйлчилгээг хийлгэх, бэлэн байдлыг хангах ажлыг зохион байгуулах;

59.1.5 хэрэв халаалтын улирал эхлэхээс өмнө зөрчил илэрч, түүнийг арилгах боломжгүй бол эрчим хүчний мэргэжлийн хяналтын эрх бүхий этгээдийн шийдвэрээр тухайн дулааны барилга байгууламжийг богино хугацаанд буюу тухайн халаалтын улирал дуусах хүртэл хугацаагаар ашиглахыг зөвшөөрч болох ба зөрчлийг дараагийн улирал эхлэхээс өмнө арилгах үүрэг хүлээнэ.

59.2 Орон нутгийн засаг захиргаа нь төвлөрсөн болон хэсэгчилсэн дулаан хангамжийн системийн байгууллагуудын халаалтын улирлын бэлэн байдлыг газар дээр нь үнэлж, нэгдсэн тайланг жил бүрийн 9 дүгээр сарын 01-ны дотор Төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

59.3 Төрийн захиргааны төв байгууллага нь улсын хэмжээнд дулаан хангамжийн байгууллагуудын халаалтын улирлын бэлэн байдлыг хангасан байдлыг халаалтын улирал эхлэхээс өмнө нэгдсэн байдлаар үнэлж, үнэлгээний дүгнэлт, авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний чиглэлийг жил бүрийн 9 дүгээр сарын 15-ны дотор орон нутгийн засаг, захиргааны байгууллагад хүргүүлнэ.

59.4 Төвлөрсөн дулаан хангамжийн системд диспетчерийн зохицуулалт хийх эрх бүхий этгээд нь тухайн орон нутагт халаалтын улиралд мөрдөх сүлжээний усны температурын графикийг батална.

59.5 Нийслэл, улсын зэрэглэлтэй хотод Диспетчериин зохицуулалт хийх эрх бүхий этгээд нь дулаан үйлдвэрлэгч, дамжуулагч байгууллагатай хамтран халаалтын улиралд гадна агаарын температурт тохируулан дулаан түгээлтийн төлөвлөгөөг өмнөх хуанлийн жилийн 9-р сарын 1-ний өдрөөс өмнө эрх бүхий байгууллагаас тогтоосон журмын дагуу боловсруулж батална.

59.6 Аймаг, суманд дулаан дамжуулах (түгээх) байгууллага нь дулаан үйлдвэрлэгч байгууллагатай хамтран халаалтын улиралд гадна агаарын температурт тохируулан дулаан түгээлтийн төлөвлөгөөг өмнөх хуанлийн жилийн 9-р сарын 1-ний өдрөөс өмнө эрх бүхий байгууллагаас тогтоосон журмын дагуу боловсруулж батална.

60 дугаар зүйл. Тоноглолыг засварлах, ашиглалтаас гаргах

60.1 Төвлөрсөн дулаан хангамжийн системийн эх үүсгүүр, дамжуулах, түгээх сүлжээг засварлах, ашиглалтаас гаргах тухайгаа дулаан хангамжийн байгууллага нь тухайн дулаан хангамжийн бүсийн харьяаны хотын Захирагч, аймгийн Засаг даргад бичгээр мэдээлэх үүрэгтэй.

60.2 Дулааны эх үүсгүүр ашиглалтаас гарах тохиолдолд таван жилийн өмнө бичгээр мэдээлэх үүрэгтэй. Хэрэв ашиглалтаас гарах дулааны эх үүсгүүрийг орлуулах боломжгүй бөгөөд дулааны эрчим хүчний дутагдал үүсэх эрсдэлтэй гэж үзвэл тухайн дулаан хангамжийн бүсийн харьяаны хотын Захирагч, аймгийн Засаг дарга нь дулаан хангамжийн байгууллагад дараах хувилбаруудыг хэрэгжүүлэхийг санал болгоно:

60.2.1 дулааны эх үүсгүүрийн үйл ажиллагааг үргэлжлүүлэх нөхцөлтэйгөөр дулааны эх үүсгүүрийг худалдах;

60.2.2 дулааны эх үүсгүүрийг тухайн хот, аймаг, бүс нутгийн захиргааны байгууллагад Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу зах зээлийн үнээс өндөргүй үнээр, талуудын харилцан тохиролцсон нөхцөлөөр худалдах.

60.3 Дулаан хангамжийн байгууллагаас дулааны эх үүсгүүрийг ашиглалтаас гаргах тухай бичгээр мэдэгдэл хүлээн авсан тохиолдолд хотын Захирагч, аймгийн Засаг дарга дулаан хангамжийн хөгжлийн төлөвлөгөө (схем)-д үндэслэн дулааны дутагдал үүсэх эрсдэлд дүн шинжилгээ хийж, ашиглалтаас хасагдсан дулааны эх үүсгүүрийн оронд орлуулах боломжийг судлах үүрэгтэй.

61 дүгээр зүйл. Технологийн зөрчлийн үед дулаан хангамжийг хязгаарлах болон таслах

61.1 Технологийн зөрчлийн үед аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх эсхүл түүнийг арилгах шуурхай арга хэмжээ авах зорилгоор дулаан үйлдвэрлэх эсхүл дулаан дамжуулах, түгээх байгууллага нь дулаан хангамжийг хязгаарлах, эсхүл таслах, хэрэглэгчийн тоноглолыг салгах эрхтэй. Энэ үед хэрэглэгчид болон хотын Захирагч, аймгийн Засаг даргад дулаан хангамжийг хязгаарлах болон таслах болсон шалтгаан, хугацааг даруй мэдэгдэнэ.

61.2 Дулаан хангамжийн үйл явцад тасралтгүй үргэлжлэх технологийн процессыг ашиглаж буй хэрэглэгчийн тоноглолд гэнэт зогсолт гарах нь хүний амь нас, эрүүл мэнд, байгаль орчинд аюул учруулж болзошгүй тохиолдолд, дулаан хангамжийн байгууллага тухайн технологийн процессыг дуусгахад шаардагдах хамгийн бага дулааны чадлын түвшинд хүртэл бууруулах үүрэгтэй.

61.3 Дулаан хангамжийг онцгой байдлын нөхцөлд хязгаарлах, таслах үед онцгой байдлын жагсаалтад багтсан хэрэглэгчийн дулааны хангамжийг хязгаарлах, таслахыг хориглоно.

61.4 Технологийн зөрчлөөс сэргийлэх эсхүл арилгах шуурхай арга хэмжээ авах зорилгоор хэрэглэгч өөрийн дулааны тоноглолыг салгах эрхтэй бөгөөд салгалтын шалтгаан болон хугацааг дулаан хангамжийн байгууллагад даруй мэдэгдэнэ.

61.5 Төвлөрсөн дулаан хангамжийн системийн дулаан хангамжийн байгууллага нь дулаан хангамжийн хязгаарлалт, салгалт ба онцгой байдлын үеийн хуваарийг боловсруулж, холбогдох дулаан хангамжийн бүсийн харьяаны харьяаны хотын

Захирагч, аймгийн Засаг даргатай зөвшилцэж батална.

61.6 Энэ хуулийн 61.5-д заасан хуваарийг жил бүр боловсруулж, түлш, дулааны эрчим хүчний болон чадлын дутагдал, эсхүл дулааны сүлжээнд дулаан зөөгчийн нийлүүлэлтэд зөрчил гарах тохиолдолд технологийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, түүнийг арилгах болон хэрэглэгчийг үндэслэлгүй таслахаас сэргийлэх зорилгоор хэрэглэгчдэд танилцуулна.

61.7 Дулаан хангамжийн хязгаарлалтын хэмжээ болон дарааллыг тодорхойлоходоо үйлдвэрлэлийн төрөл, эдийн засаг, нийгмийн ач холбогдол, технологийн онцлогийг харгалзан үзэж, үүсэх хохирол хамгийн бага байхаар боловсруулж, төлөвлөнө.

61.8 Энэ хуулийн 61.5-д заасан хуваарыт орохгүй хэрэглэгчдийн жагсаалтыг дулаан хангамжийн байгууллага хотын Захирагч, аймгийн Засаг дарга зөвшилцэн батална.

61.9 Энэ зүйл нь бие даасан болон хэсэгчилсэн дулаан хангамжийн системд хамаарахгүй.

АРВАН ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ХЯНАЛТ ШАЛГАЛТ

62 дугаар зүйл. Мэргэжлийн хяналт шалгалт

62.1 Монгол Улсын дулаан хангамжийн найдвартай ажиллагаа, аюулгүй байдлыг хангах зорилтын хүрээнд энэ хууль болон холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн дулаан хангамжийн байгууллагын үйл ажиллагааны зорилт, үр дүнг үнэлэх, дулааны барилга байгууламж, тоног төхөөрөмж нь техник, технологийн норм, стандартын шаардлага, ашиглалтын болон аюулгүй ажиллагааны шаардлагыг хангасан эсэх болон салбарын мэргэжилтэй ажилтнуудын мэдлэгийн түвшин зохих шаардлагад нийцсэн байдал зэрэгт мэргэжлийн хяналт, шалгалт хийгдэнэ.

62.2 Мэргэжлийн хяналт шалгалт нь дараах төрөлтэй байх ба төрөл тус бүрээр хяналт, шалгалт хийх журмыг төрийн захиргааны төв байгууллага боловсруулж, батална:

- 62.2.1 урьдчилсан хяналт шалгалт;
- 62.2.2 алсын зайн хяналт шалгалт;
- 62.2.3 газар дээрх хяналт шалгалт.

63 дугаар зүйл. Урьдчилсан хяналт шалгалт хийх

63.1 Урьдчилсан хяналт шалгалт нь дулаан хангамжийн байгууллага болон түүний барилга байгууламж дээр очихгүйгээр, цуглуулсан мэдээлэл, мэдээллийн систем ашиглан мэдээллийг шинжлэх замаар үйл ажиллагаанд хяналт тавих үйл явц байна.

63.2 Энэ хуулийн 62.2-т заасан журамд урьдчилсан хяналт шалгалт хийхтэй холбоотой дараах асуудлуудыг тусгасан байна:

- 63.2.1 журмын үйлчлэх хүрээ, оролцох субъектүүд;
- 63.2.2 урьдчилсан хяналт шалгалтад хамрагдах дулаан хангамжийн байгууллага;

63.2.3 урьдчилсан хяналт шалгалтад хамрагдах дулааны барилга байгууламж, тоног төхөөрөмж;

63.2.4 хяналт шалгалт хийхэд шаардлагатай өгөгдөл, мэдээлэл, түүнийг бүртгэх;

63.2.5 өгөгдөл, мэдээллийг салбарын төрөлжсөн мэдээллийн сан болон мэдээллийн нэгдсэн системд дамжуулах үйл явц, дараалал, хугацаа.

63.3 Дулааны хангамжийн байгууллага болон дулааны барилга байгууламж, тоног төхөөрөмж дээр очилгүйгээр урьдчилсан хяналт шалгалт хийх ажлыг нэг жилд хоёроос дээшгүй удаа хэрэгжүүлнэ.

64 дүгээр зүйл. Алсын зайн хяналт шалгалт

64.1 Алсын зайн хяналт шалгалт нь урьдчилсан хяналт шалгалтаар илэрсэн зөрчил эсхүл үндэслэл бүхий тайлан, мэдээллээр илэрсэн зөрчлийг арилгах үйл явцад мэдээллийн систем ашиглан зайнлас хяналт тавих үйл явц юм.

64.2 Энэ хуулийн 62.2-т заасан журамд алсын зайн хяналт шалгалт хийхтэй холбоотой дараах асуудлуудыг тусгасан байна:

64.2.1 урьдчилсан хяналт шалгалтын хүрээнд илэрсэн зөрчлийг арилгах зөвлөмж, шаардлага гаргах, түүнийг холбогдох байгууллагад хүргүүлэх үйл явц, хугацаа;

64.2.2 үндэслэл бүхий тайлан, мэдээллээр илэрсэн зөрчлийг арилгах зөвлөмж, шаардлага гаргах, түүнийг холбогдох байгууллагад хүргүүлэх үйл явц, хугацаа;

64.2.3 илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээг хянахтай холбоотой мэдээлэл гаргах, мэдээллийн системд дамжуулах үйл явц, дараалал, хугацаа;

64.2.4 илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээний биелэлтэд хяналт, шалгалт хийх, дүгнэх зохицуулалт.

65 дугаар зүйл. Газар дээрх хяналт шалгалт

65.1 Газар дээрх хяналт шалгалт нь төлөвлөгөөт ба төлөвлөгөөт бус хэлбэртэй байна.

65.2 Төлөвлөгөөт хяналт шалгалт нь эрх бүхий этгээдийн жилийн хяналт шалгалтын хуваарийн дагуу хийгдэнэ.

65.3 Жилийн хяналт шалгалтын хуваарийг өмнөх оны 12 дугаар сарын 10-ны өдрөөс өмнө баталж, 12 дугаар сарын 20-ны өдрөөс өмнө эрх бүхий байгууллагын цахим хуудсанд нийтэлнэ.

65.4 Жилийн хяналт шалгалтын хуваарийг гаргахдаа үндсэн тоног төхөөрөмжийн элэгдлийн зэрэг болон технологийн зөрчлийн тоо хэмжээ, ангилал, эрсдэл зэрэг үзүүлэлтэд үндэслэнэ:

65.4.1 үндсэн тоног төхөөрөмжийн элэгдлийн зэрэг нь 50 хувь хүртэл бол бага эрсдэлтэй, 51-75 хувь бол дунд эрсдэлтэй, 75 хувиас дээш бол өндөр эрсдэлтэй гэж үнэлнэ;

65.4.2 технологийн зөрчлөөр II түвшний saat ал бүртгэгдсэн бол бага

эрсдэлтэй, I ба II түвшний саатал бүртгэгдсэн бол дунд эрсдэлтэй, осол, I ба II түвшний саатал зэрэг бүртгэгдсэн бол өндөр эрсдэлтэй гэж үнэлнэ.

65.5 Бага эрсдэлтэй гэж үнэлэгдсэн тохиолдолд төлөвлөгөөт хяналт шалгалтыг хоёр жилд нэг удаа, дунд болон өндөр эрсдэлтэй гэж үнэлэгдсэн тохиолдолд жилд нэг удаа хийнэ.

65.6 Жилийн хяналт шалгалтын хуваарийг салбарын төрөлжсөн мэдээллийн сан, мэдээллийн нэгдсэн системд үндэслэн автоматаар гаргана. Хэрэв ийнхүү автоматаар гаргах боломжгүй бол эрх бүхий этгээд элэгдлийн зэрэг, технологийн зөрчлийн тоо хэмжээнд үндэслэн бие даан боловсруулна.

65.7 Төлөвлөгөөт бус хяналт шалгалт нь дараах нөхцөл байдалд зөрчил, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эсхүл түүнийг арилгах зорилгоор тодорхой байгууллага эсхүл дулааны барилга байгууламж, тоног төхөөрөмжид эрх бүхий этгээдээс зохион байгуулах хяналт шалгалт байна:

- 65.7.1 хүний амь нас, эрүүл мэндэд аюул учирч болзошгүй нөхцөл байдал;
- 65.7.2 байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэх нөхцөл байдал;
- 65.7.3 хувь хүн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол, улс орон, нийтийн ашиг сонирхолд аюул учирч болзошгүй нөхцөл байдал.

65.8 Төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг дараах үндэслэлээр явуулна:

- 65.8.1 I зэргийн осол, доголдлын судалгааны үр дүнд гарсан арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх хяналт тавих;
- 65.8.2 алсын зайн хяналтын дүгнэлтэд заасан арга хэмжээг хэрэгжүүлээгүй, эсхүл зөрчлийг арилгасан тухай мэдээлэл өгөөгүй тохиолдол;
- 65.8.3 хувь хүн, хуулийн этгээдээс ирүүлсэн, дулааны хангамжийн тухай хууль тогтоомжийг зөрчсөн баримт, нотолгоотой өргөдөл, гомдол;
- 65.8.4 эрх бүхий байгууллагаас баталсан технологийн зөрчлийн ангиллын дагуу I зэргийн осол, зөрчлийн тухай албан ёсны эх сурвалжаас ирсэн мэдээлэл;
- 65.8.5 төлөвлөгөөт шалгалтын үр дүнгээр гарсан зөрчлийг арилгах тухай шийдвэрийн хэрэгжилтийг хянах, хэрэв хяналтын субъект нэгээс олон удаа зөрчлийг арилгасан талаар мэдээлэл өгөөгүй эсхүл зөрчлийг арилгаагүй бол;
- 65.8.6 прокурорын шаардлагаар хүний амь нас, эрүүл мэнд, байгаль орчинд учирсан эсхүл учирч болзошгүй аюултай холбогдсон тодорхой баримтын дагуу шалгалт хийх;
- 65.8.7 төрийн байгууллагаас ирүүлсэн хүний амь нас, эрүүл мэнд, байгаль орчинд учирсан хохирол, хувь хүн болон хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн тухай баримт бүхий хүсэлт;
- 65.8.8 хуульд заасан бусад үндэслэл.

65.9 Төлөвлөгөөт бус хяналт шалгалт эхлэхээс хамгийн багадаа 24 цагийн өмнө хяналт шалгалтад хамрагдах байгууллагад мэдэгдсэн байна.

65.10 Онцгой байдал, гэнэтийн болон давагдашгүй хучин зүйлсийн нөхцөл байдал үүссэн үед энэ хуулийн 65.9-д заасны дагуу мэдэгдэхгүй байж болно.

66 дугаар зүйл. Хяналт шалгалт хийх журам

66.1 Эрх бүхий этгээд хяналт, шалгалт хийхдээ Төрийн хяналт шалгалтын тухай хуулийг удирдлага болгоно.

67 дугаар зүйл. Үйлдвэрлэлийн хяналт шалгалт

67.1 Дулаан хангамжийн салбар дахь үйлдвэрлэлийн хяналт шалгалт нь төвлөрсөн дулаан хангамжийн системд үйл ажиллагаа явуулдаг дулаан үйлдвэрлэх болон дамжуулах, түгээх аж ахуйн нэгжүүдийн эзэмшил, өмчлөлийн дулааны барилга байгууламж, тоног төхөөрөмж, бусад обьектуудад хийгдэнэ.

67.2 Үйлдвэрлэлийн хяналт шалгалтын зорилго:

67.2.1 Монгол Улсын дулаан хангамжийн хууль тогтоомжийн шаардлагыг мөрдүүлэх;

67.2.2 дулааны барилга байгууламж, сүлжээ, техник, тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааг хянах;

67.2.3 дулаан хангамжийн чанар, найдвартай байдал, системийн аюулгүй байдлыг хангах;

67.2.4 техник ашиглалтын дүрэм, аюулгүй ажиллагааны дүрмийн шалгалтад тэнцсэн ажилтнуудаар ажлыг гүйцэтгүүлэх;

67.2.5 дулааны барилга байгууламж, сүлжээ, техник, тоног төхөөрөмжийг үйл ажиллагааны бэлэн байдалд байлгах;

67.2.6 намар, өвлийн улиралд дулаан үйлдвэрлэх, дамжуулах, түгээх байгууллагын засвар, сэргээн босголтын ажлыг цаг тухайд нь хэрэгжүүлэх;

67.2.7 хөдөлмөрийн аюулгүй ажиллагаанд нөлөөлсөн нөхцөл, шалтгааныг тодорхойлох;

67.2.8 технологийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах.

67.3 Үйлдвэрлэлийн хяналт шалгалт явуулах журам:

67.3.1 төвлөрсөн дулаан хангамжийн системд ажилладаг дулаан үйлдвэрлэх болон дамжуулах байгууллагууд үйлдвэрлэлийн хяналт шалгалтын журам боловсруулна;

67.3.2 үйлдвэрлэлийн хяналт шалгалтын стандарт журмыг эрх бүхий байгууллага боловсруулж, батална.

67.4 Үйлдвэрлэлийн хяналт шалгалт хэрэгжүүлэгч албан тушаалтныг дулаан үйлдвэрлэх болон дамжуулах аж ахуйн нэгжүүдийн удирдлага томилж, тухайн албан тушаалд тавигдах мэргэшлийн шаардлага, ажлын туршлага, бутцийн нэгжийн удирдлагын түвшинд ажиллах албан тушаалд нийцэж буй эсэхийг эрчим хүчний мэргэжлийн хяналт шалгалтын эрх бүхий этгээдийн зөвшөөрлөөр баталгаажуулна.

67.5 Үйлдвэрлэлийн хяналт шалгалт хэрэгжүүлэгч албан тушаалтны үүрэг:

67.5.1 үйлдвэрлэлийн хяналт шалгалтын ажлын төлөвлөгөө боловсруулах;

67.5.2 ажилтнуудыг дулаан хангамжийн хууль тогтоомжийн шаардлагыг мөрдүүлэхэд хяналт тавих;

- 67.5.3 дулааны объект, үйлдвэрлэлийн хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг хангах үзлэг зохион байгуулах;
- 67.5.4 хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг хангах, технологийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ боловсруулах;
- 67.5.5 дулаан үйлдвэрлэх болон дамжуулах, түгээх байгууллагын ажилтнуудад хууль тогтоомжийн өөрчлөлтийн талаар мэдээлэх;
- 67.5.6 удирдлагад дараах асуудлаар санал өгөх:
- 67.5.6.а. аюулгүй ажиллагааг хангах арга хэмжээ;
- 67.5.6.б. хууль тогтоомжийн шаардлагыг зөрчсөн ажлыг зогсоох;
- 67.5.6.в. сургалт, дахин сургалтад хамрагдаагүй ажилтнуудыг ажиллуулахыг зогсоох.
- 67.5.7 хууль тогтоомжид заасан бусад эрх, үүргийг хэрэгжүүлэх.
- 67.6 Үйлдвэрлэлийн хяналт шалгалт хэрэгжүүлэгч албан тушаалтны эрх:
- 67.6.1 дулааны объект, түүнд хамаарах барилга байгууламжид хүссэн цагтаа саадгүй нэвтрэх;
- 67.6.2 өөрийн хамаарах асуудлын хүрээнд цаасан болон цахим хэлбэрийн баримт бичиг, мэдээллийг авах, мөн автоматжуулсан мэдээллийн санд хандах эрхтэй.

АРВАН ТАВДУГААР БҮЛЭГ. ХАРИУЦЛАГА

- 68 дугаар зүйл. Төр, захиргааны байгууллага, албан тушаалтны хүлээх хариуцлага
- 68.1 Төр, захиргааны байгууллага, албан тушаалтан дулаан хангамжийн талаар энэ хуулиар хүлээсэн бүрэн эрх, эсхүл түүнийг хэрэгжүүлэхэд хамаарах бусад хууль тогтоомжоор хүлээсэн бүрэн эрхээ хуулийн дагуу хэрэгжүүлээгүй тохиолдолд холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээнэ.
- 69 дугаар зүйл. Зохицуулах хорооны зөрчил, маргаан хянан шийдвэрлэх эрх хэмжээ
- 69.1 Зохицуулах хорооны улсын байцаагчийн эрх бүхий хяналт шалгалтын ажилтан нь дулаан хангамжийн байгууллага энэ хууль эсхүл энэ хуульд заасан гэрээний хэрэгжилтийг хангуулахад хяналт тавина.
- 69.2 Энэ хуулийн 66.1-д заасан хяналт шалгалт нь мэргэжлийн болон үйлдвэрлэлийн хяналт шалгалтын харьяаллын асуудалд хамаарахгүй байна.
- 69.3 Энэ хуулийн 66.1-д заасан хяналт шалгалтыг Зохицуулах хорооны улсын байцаагчийн эрх бүхий хяналт шалгалтын ажилтан Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн дагуу хэрэгжүүлж, илэрсэн зөрчилд Зөрчлийн хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.
- 69.4 Энэ хуулийн 66.1, 66.2-т зааснаас бусад тохиолдолд салбарын оролцогч талуудын хооронд үүссэн маргааныг Зохицуулах хорооны улсын байцаагчийн эрх бүхий хяналт шалгалтын ажилтан хариуцаж, гомдол хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор урьдчилан хянан шийдвэрлэнэ. Энэ хугацааг шаардлагатай бол 30 хоногоор сунгаж болно.
- 69.5 Энэ хуулийн 66.4-т заасны дагуу гаргасан шийдвэрийг талууд эс зөвшөөрвөл шийдвэрийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор шүүхэд гомдол гаргаж шийдвэрлүүлнэ.